

Гарчиг

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	2
2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА	5
2.1 Уур амьсгал	5
2.2 Ус зүй ба гидрогеологийн нөхцөл	5
2.3 Хөрс, Ургамлан бүрхэвч	5
2.4 Нийгэм, Эдийн засаг	6
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	6
3.1 Байгаль орчны асуудал, нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээний хүснэгт	9
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	11
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	12
5.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12
5.2 Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах төлөвлөгөө	20
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	24
7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА	24
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ	25
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ	26
10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	26
11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	34
11.1 Аюултай хог хаягдал	45
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	47
12.1 Агаарын чанар хяналт шинжилгээ	45
13. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	45
14. НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	51
15. БАЙГАЛТ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨВ	51

16. ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР55

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Оршил

Уул уурхай үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг зөв оновчтой тодорхойлж түүнийг арилгах, багасгах, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх нь хариуцлагатай уул уурхайн үндсэн зарчмуудын нэг юм.

“Пи Эй Ар Эй Эн” ХХК нь орон нутаг болон бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулах, байгаль орчны хамгааллын асуудалд ач холбогдол өгөн ажиллаж байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10-р сарын 2-ны өдрийн А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын хавсралтад заасны дагуу боловсруулсан.

1.2 Уурхайн үйл ажиллагаа явагдаж буй газрын засаг, захиргааны харьяалал

“Пи Эй Ар Эй Эн” ХХК ХХК-ийн эзэмшилд байгаа Дорнод аймгийн Матад сумын нутагт орших MV-015616 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл нь 1:100000-ны масштабтай байр зүйн зургийн L-50-4 хавтгайд буюу газар зүйн доорх солбицлоор хязгаарлагдан оршино.

Талбайн хэмжээ-**1684.39 га.**

Хүснэгт 1. ашиглалтын тусгай зөвшөөрлийн булангийн цэгүүд


Т.3 дугаар	Цэгийн дугаар	Газарзүйн солбицол						Тэгш өнцөгтийн болбицол	
		ӨРГӨРӨГ			УРТРАГ			Х	Ү
MV-015616	1.	47°	48'	41.85"	115°	36'	2.54"	5296311.397	395240.509
	2.	47°	48'	41.85"	115°	32'	55.25"	5296383.201	391345.688
	3.	47°	51'	1.94"	115°	32'	55.25"	5300708.055	391426.900
	4.	47°	51'	1.94"	115°	36'	2.54"	5300636.261	395318.809

“Пи Эй Ар Эй Эн” ХХК-ийн MV-015616 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл нь хот суурин газраас дараах зайд алслагдана.

Хүснэгт 2. ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн байршил

№	Хот суурин газрын нэр	Зүг, чиг	Зай, км
1	Улаанбаатар хот	зүүн	752
2	Чойбалсан хот	Зүүн урагш	90

3	Матад сум	Зүүн хойш	137
---	-----------	-----------	-----



Зураг 1. Баян-Ус нүүрсний ордын лицензийн талбайн байршлийн зураг

1.3 Түүхэн товчоо

“Пи Эй Ар Эй Эн” ХХК-ийн “Баян усны хүрэн нүүрсний ордыг ил аргаар ашиглах” төсөл нь 1684.39 га талбай бүхий MV-015616 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай эзэмшдэг.

Баян-Усны ордод 2009 онд ашиглалтынажил хийн тус ашиглалтынажлын үр дүнд үндэслэн ашиглалтынажлын үр дүнгийн тайланг боловсруулан ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн ордын нөөцийг 2010 оны 03-р сарын 01-ний байдлаар “А+В+С” зэрэглэлээр нийт 52,041.66 мян.тн нүүрс гэж тооцон батлуулсан байдаг.

Тухайн цагаас хойш Баян-Усны ордод ашиглалтын үйл ажиллагаа огт явуулаагүй тул дээрх ашиглалтынажлын үр дүнд үндэслэн ТЭЗҮ-ийг тодотголыг боловсрууллаа. ТЭЗҮ-ийг тодотгох үндэслэл нь уурхайн ирээдүйн хэтийн төлвийг тодруулах, 2011 онд боловсруулж байсан ТЭЗҮ-ийн тодотголын хүчинтэй хугацаа дууссан зэрэг шалтгааны улмаас ТЭЗҮ-ийн тодотголыг боловсрууллаа.

Төсөлд ил уурхайн жилийн хүчин чадал 3,000.0 мян.тн нүүрс буюу ил уурхайн ашиглалтын хугацаа 9 жил байхаар тооцож төслийг боловсруулсан.

“Баян усны хүрэн нүүрсний ордыг ил араар ашиглах” төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний судалгааны багт Химийн бодисын эрсдэлийн үнэлгээний шинжээчээр ШУА- Хими-хими технологийн хүрээлэнгийн ЭШТА Г.Бурмаа (Ph.D), хөрс судлаач Б.Энхбаяр (M.Sc), ургамал судлаач Ч.Мөнгөнчимэг (M.Sc), агаарын чанарын шинжээч Б.Бархасрагчаа (M.Sc) болон “Найчрал Састайнэблэ” ХХК-ийн захирал М.Ганхуяг, мэргэжилтэн Д.Оюунжаргал (M.BA), Х.Уянга (M.Sc), Х.Батдорж (M.Sc) нар ажиллаасан.

1.4 “Баян-Ус” ордын геологийн тогтоц

Баян усны нүүрсний ордыг агуулж байгаа хурдас нь зүүн хойш баруун урагш чиглэсэн доод цэрдийн адуун чулуун формацийн хурдсаар дүүргэгдсэн Баян усны жижиг хотгор бүтцийн хэмжээнд хурдасны зүсэлтийн дээд хэсэгт өргөн тархсан нүүрслэг багцын хэмжээнд тохиолдоно. Нүүрс агуулсан хотгорын бүтцийн дунд болон захаар нь харьцангуй өндөр гадаргуу үүсгэсэн триас болон бялхмал чулуулаг илрэх ба эдгээр нь өндөр дэвсэг, мөргөцөг үүсгэх хилтэй цагаан-цайвар хөрзөн зонхилсон миоцений хурдсаар хучигдана. Ерөнхийдөө хотгор бүтцийн баруун хойт хэсэгт байрладаг байна. Хотгор нь зүүн хойш чиглэлтэй тектоник хагарлуудаар хянагдана. Хээрийн судалгааны ажиглалтаар нүүрсний орд агуулж байгаа Баян усны хотгор үндсэндээ бүрэн дарагдсан, хайгуулын 0 шугамын 020-р цооногийн хойт хэсэгт ухмал болон шатаж буй нүүрсний асрага тод ажиглагдах ба энд хэдэн мм-ийн болон хэдэн арван см хэмжээтэй нүүрсний гялалзсан хар өнгийн давирхайлаг нүүрсний хэлтэрхий элбэг тохиолдох аж. Хайгуулын ажлаар энэхүү шатаж байгаа хэсэг нь ордын зүүн хойт талын салаалж байгаа хэсэг болох ба нүүрс хуримтлагдсан хотгорын захын хэсэг гэж тооцжээ.

Нүүрсний үе нь ихэвчлэн хар саарал наангжин, наангийн үетэй янз бүрийн мөхлөгтэй элсжингийн зузаалагт орших агаад энэ хурдас дээр нийцлэгээр 30-50 м өндөр мөргөцөг үүсгэсэн хайргажингийн үеүдтэй маш сайн мөлгөржсөн олон найрлагат жижиг дунд хэмжээний хайргат хөрзөнгөөр хучигддаг аж. Хайгуулын үед хучсан хурдсыг харьцуулах аргаар, хурдсын гадаргуугийн хэв шинж, литологийн онцлогийг харгалзан миоцений насанд хамааруулсан аж.

Хайгуулын өрөмдлөгөөр илрүүлсэн нүүрсний давхраасууд нь баруун хойш чиглэсэн моноклиналь структур үүсгэх ба хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий хил залгаа хэсэгт бага шургасан нүүрсний давхраасууд нь тогтвортой үргэлжилдэг байна.

1.5 Уулын ажлын ерөнхий мэдээлэл

2024 он хүртэл төслийн талбайд олборлолтын ажил явагдаагүй болно.

1.6 2025 оны уулын ажлын төлөвлөлт

2025 онд Баян-Ус уурхайгаас 5.17 сая м3 хөрс хуулж, 0.52 сая тн нүүрс олборлох буюу нийт 5.57 сая м3 уулын цулын ажил гүйцэтгэнэ. Сард дунджаар 0.46 сая м3 уулын цулын ажил

гүйцэтгэнэ. Мөн 524.98 тн хүрэн нүүрс олборлох төлөвлөгөөтэй хэдий ч бичиг баримт бүрдэл болон холбогдох зөвшөөрөл авах хугацаа шаардлагатай байгаа тул 2025 онд бэлтгэл ажил хийх судалгаа хийх ажилд зарцуулах төлөвлөгөөтэй байна.

2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА

2.1 Уур амьсгал

Тус бүс нутгийн цаг уурын төлөв байдал нь эх газрын эрс тэс шинжтэй тул өвлийн улирал нь урт хүйтэн, зун нь богино дулаан, харин хавар, намрын улирал нь богиновтор, хүйтний солилцоо их байдаг байна. Хамгийн дулаан үе нь 7-р сар, хүйтэн нь 1–р сард тохиолдох аж. Жилийн дундаж температур $0^{\circ}\sim+2^{\circ}$ С байдаг байна.

Салхины зонхилох чиглэл нь баруун хойноос болон зүүн хойноос чиглэлтэй байдаг байна. Өвөл 11-р сард эхэлж, 3-р сарын сүүлчээр хаврын урь орж, 6-р сард зуны улирал эхлэн 8-р сарын сүүлчээс намрын уур амьсгал ордог байна. Жилийн туршид салхитай өдрүүд зонхилдгоос хөрсний чийгшил маш муу, хуурайшил ихтэй аж. Агаарын даралт улирал бүрд харилцан адилгүй, жилийн дундаж даралт 1022– 1034 м/б, харин хаврын улиралд агаарын даралт тогтворгүй 20–12 м/б–аар багасах бөгөөд энэ нь салхи ихтэй чиглэл нь тогтворгүй болох нөхцлийг бүрдүүлдэг байна.

2.2 Ус зүй ба гидрогеологийн нөхцөл

Районы хэмжээнд тархсан газар доорхи усны байршлын нөхцлөөр нь дараах гурван уст үеүүдэд ангилсан байна. Үүнд:

1. Дөрөвдөгчийн хурдсын (QIII-IV) газар доорхи уст үе;
2. Цэрдийн (K1) хурдсын уст давхрага;
3. Интрузив болон хувирмал чулуулгийн ан цавын ус;

Дөрөвдөгчийн хурдсын уст үе (QIII-IV): Тусгай зөвшөөрлийн талбайд тархсан дөрөвдөгчийн настай сэвсгэр хурдас нь элюви, делюви, пролювийн гаралтай 3-7 м зарим тохиолдолд 10 м зузаантай хонхор хотос, жижиг жалга гуунд ихэвчлэн тогтдог байна. Ус агуулсан хурдас нь элс, жижиг хайргатай элсэнцэр, шавранцар, лаг шавраас бүрдэх ба энэ хурдсын усны түвшин нь газрын рельефийн байдлаас хамаарч харилцан адилгүй байдаг байна. Энэ хурдсын усны шинж төрхийг өмнөх судлаачдын үр дүн болон дээжийн шинжилгээний дүнгээс үзэхэд усны эрдэсжилт нь голдуу 0.6-0.8 г/л заримдаа 1.2 г/л хүрдэг бөгөөд усан хангамжийн хэмжээ нь хур тунадасны хэмжээнээс шалтгаална гэж үздэг байна.

2.3 Хөрс, Ургамлан бүрхэвч

Орд нь хээрийн бүсийн хүрэн, хар хүрэн хөрсний бүсэд хамаарна. Хээрийн хүрэн, хар хүрэн хөрсний ургамалжилт нь малын тэжээлийн зонхилох хэсгийг бүрдүүлэх ба энд дааган сүүл, хазаар өвс, бутуул, ерхөг, согоовор, хиаг, агь, таана зэрэг шим тэжээл сайтай өвс ургамал ноёрхох тул бэлчээрийн чанарын хувьд илүү сайн аж.

2.4 Нийгэм, Эдийн засаг

Дорнод аймаг нь 2024 оны байдлаар нийт 84,604 хүн бүртгэгдсэнээс Матад

суманд 2350 хүн бүртгэгдсэн байна. Уурхайн талбайтай аймгийн төвөөс 150 км,

нийслэл Улаанбаатар хотоос 752 км-т алслагдсан бөгөөд Сүхбаатар аймаг болон өөрийн аймгийн Булган, Баянтүмэн, Халхгол, Сүмбэр сум болон БНХАУ-тай хиллэдэг.

Газрын тос, уран, нүүрс, жонш, шохой, алт зэрэг ашигт малтмалтай.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийг матрицын аргаар үнэлсэн үнэлгээнээс нэгтгэн авч үзвэл нөлөөллийн хэлбэрийн хувьд нийт нөлөөллийн 80% нь шууд, 20% шууд бус хэлбэрээр, хугацааны хувьд 88 хувь нь урт хугацаанд, 12 хувь нь богино хугацаанд, ихэнх нөлөөлөл нь буцалтгүй хэлбэрээр нөлөөлөхөөр байна. Харин тус матрицад авч үзсэн нийт нөлөөллийг эрчмийн хувьд авч үзвэл 42.3 хувь нь хүчтэй буюу их, 46.1 хувь нь дунд, 11.6 хувь нь бага зэргийн нөлөөлөл байна.

Төслөөс нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах:

- Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах
- Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийг баримталж ажиллах /Засгийн Газрын 2019 оны 313 дугаар тогтоолын хавсралт/
- Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр хамруулах
- Техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд байнгын хяналт тавих
- Ажилчдын ажлын байрны аюулгүй Уурхайн үйл ажиллагаагаар үүссэн нарийн ширхэглэгт тоосонцор нь салхиар зөөгдөн оршин суугчид, ажиллагсдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлж, ажиллагсдад тусгай зориулалтын амны хаалт, хэрэгсэл олгох
- Ажиллагсдыг жил бүр эрүүл мэндийн үзлэгт оруулж, уурхайн ажилчдын өвчлөлтийн талаар судалгаа дүгнэлт гаргуулах
- Хоолны газар, ажлын байрны эрүүл ахуйд хяналт тавьж ажиллах
- Дуу чимээ ихтэй нөхцөлд ажиллах ажиллагсдад зориулалтын чихний бөглөө олгох
- Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх багаж хэрэгслийг ажлын байруудад зохих шаардлагын дагуу бэлтгэн байрлуулах
- Уурхайн ажилчдад хөдөлмөрийн аюулгүй байдал, аврах багийн хүрээнд тогтмол сургалтанд хамруулах
- Уурхайн тоног төхөөрөмж, ахуйн хаягдал цэг, сав агуулахуудын байрлах газрыг байгаль орчинд халгүй, хүмүүсийн аюулгүй ажиллах, амрах бүх нөхцөлийг хангах зорилгоор зөв байрлуулах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн үйл ажиллагааны үед химийн хортой болон аюултай бодисын нөлөөллөөр хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй эрсдлийг магадлалын аргаар тодорхойллоо. Ингэхдээ хүснэгт 5.10-д үзүүлсэний дагуу сөрөг нөлөөллийн түвшин, магадлал, эрсдэлийн түвшинг тодорхойлж үнэлсэн болно.

Хүснэгт 3.1 Эрсдэл үүсэх магадлалын үнэлэмж

Магадлал	Магадлал үүсэх хугацаа	
Магадлалтай	Жилд нэг удаа болох	
Болзошгүй	1-2 жилийн хугацаанд	
Боломжтой	5 жилийн хугацаанд	
Магадлал бага	5-20 жилийн хугацаанд	
Ховор	20 жилээс дээш хугацаанд	
C ¹ - Сөрөг нөлөөллийн түвшин: 1-Маш бага 2-Бага 3-Дунд 4-Их 5-Маш их	L ² - Магадлал (доорх байдлаар ангилна): AC - Магадлалтай L - Болзошгүй P - Боломжтой U - Магадлал бага R - Ховор	R ³ - Эрсдэл (дараах түвшингээр үнэлнэ)
		E - Маш их
		H - Их
		M - Дунд зэрэг
		L - Болзошгүй

Хүснэгт 3.2 Төсөл хэрэгжих явцад үүсэж болзошгүй эрсдэлийн тодорхойлолт

Тэсэлгээний үйл ажиллагаа	Үүсэх эрсдэл	Сөрөг нөлөөллийн түвшин (C ¹)	Магадлал (L ²)	Эрсдэл (R ³)	Эрсдэлээс үүсэх үр дагавар
Химийн бодисуудыг ачиж, буулгах, зөөх	Химийн бодис асгарах	2	U	L	-Амьсгалах, залгих, хүрэлцэх замаар ажилчдын эрүүл мэндийг хордуулах, түлэх, цочроох
	Сав баглаа боодлын битүүмжлэл алдагдсанаас бодис уурших, дэгдэх	2	L	M	- Орчны агаар, хөрс химийн бодисоор бохирдож, бохирдсон агаар болон хөрснөөс үүсэж буй тоосжилт нь орон нутгийн иргэд, төслийн ажилчид, мал амьтдыг агаар дусал, амьсгалын замаар хордуулах
Химийн бодисын тээвэрлэлт	Тээвэрлэлтийн горим зөрчигдсөнөөс /температур, хамт тээвэрлэж болохгүй бодис, сав баглаа боодлын битүүмжлэл алдагдах/ бодис асгарах, урвалд орох, шатах, агаарт уурших, тоос үүсгэх г.м	3	AC	M	- Тээвэрлэлтийн явцад ажиллаж буй төслийн ажилчид, орон нутгийн иргэд, мал амьтад химийн бодисын нөлөөлөлд өртөж хордох - Шатамхай, тэсэрч дэлбэрэх аюултай бодис алдагдвал галын аюул үүсэх - Тээвэрлэлт хийгдэж байсан бүс нутгийн агаар, хөрс, гадаргын болон газрын доорхи усыг бохирдуулж, улмаар хүн, мал амьтдын эрүүл мэндэд хохирол
	Орчны өөрчлөлтөөс бодисын найрлага өөрчлөгдөж тэлэх, улмаар тэсрэх	1	L	L	

	Асгарсан бодис хур борооны болон үерийн усаар гадаргын болон гүний усыг бохирдуулах	2	L	L	учруулах
Химийн бодисын хадгалалт	Хадгалалтын горим зөрчигдсөнөөс /температур, гэрэл, чийг, хамт хадгалж болохгүй бодис/ бодис асгарах, урвалд орох, шатах, тэсэрч дэлбэрэх, агаарт уурших, тоос үүсгэх г.м	3	P	M	-Уурхайн ажилчид ажлын талбай дээр шууд химийн бодисоор хордох -Химийн бодисын агуулахын ойролцоо ажиллаж, амьдарч буй орон нутгийн иргэд химийн бодисоор хордох -Орчны хөрс, агаар, газрын доорхи ус химийн бодисоор бохирдож урт хугацааны турш тухайн бүс нутгийн оршин суугчдыг хордуулж, ноцтой хохирол учруулна.
Химийн бодисын ашиглалт	Химийн бодисуудыг ашиглах явцад аюулгүй ажиллагааны нөхцөл, дүрэм журам зөрчигдсөнөөс бодис асгарах, урвалд орох, шатах, тэсэрч дэлбэрэх, агаарт уурших, тоос үүсгэж улмаар ажилчдын эрүүл мэндийг хордуулах	3	P	M	
Химийн бодисын сав баглаа боодлын хаягдал	Химийн бодисын сав баглаа боодлын хаягдлыг зохих журмын дагуу устгаагүйгээс бодисын үлдэгдэл хүрээлэн буй орчинд тархах	2	P	L	-Уурхайн ажилчид, орон нутгийн иргэд, хүрээлэн буй орчныг химийн бодисоор бохирдуулж, хордуулах -Шатамхай, галын аюултай бодисын хаягдлаас үүдэлтэй гал гарах, тэсэрч дэлбэрэх аюул үүснэ.
ХХАА-ны зөрчил	Ажилчид бодисуудын хор аюул, аюулгүй ажиллагааны талаар мэдлэг дутмаг, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл өмсөөгүйгээс химийн бодисоор хордох	3	L	L	-Химийн бодисыг хадгалах, устгах, тээвэрлэх, ачиж буулгах, зөөх явцад аюулгүй ажиллагааны дүрэм журам мөрдөөгүйгээс химийн бодисын нөлөөлөлд өртөж хордох

Байгаль орчны асуудал, нөлөөлөл Нийгэм, Эдийн засаг Байгаль орчны асуудал, нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээний хүснэгт

3.1 Байгаль орчны асуудал, нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээний хүснэгт

Хүснэгт 3.1.1 Байгаль орчны эрсдэлийн үнэлгээний түлхүүр асуулт

БОТА 1: Төслийн үйл ажиллагаанаас усны чанарт нөлөөлснөөр экосистемд ямар нөлөөлөл үзүүлж болох вэ?	Усны экосистемд хортой
БОТА 2: Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт нөлөөлснөөр экосистемд ямар нөлөөлөл үзүүлж болох вэ?	Хүчиллэг тунадас: Усны экосистем, эд материалыг муутгана. Температурын өөрчлөлтөнд нөлөөлнө.
БОТА 3: Төслийн үйл ажиллагаанаас хөрсний чанарт нөлөөлснөөр экосистемд ямар нөлөөлөл үзүүлж болох вэ?	Хөрсөнд био хуримтлал үүсгэж, ургамал амьтдад сөрөг нөлөө үзүүлнэ.
БОТА 4: Төслийн үйл ажиллагаанаас хүнсний бүтээгдэхүүний чанарт нөлөөлснөөр экосистемд ямар нөлөөлөл үзүүлж болох вэ?	Ургамал болон хүнсний сүлжээнд хуримтлал үүсгэнэ.
БОТА 5: Ус, агаар, хөрс болон хүнсний бүтээгдэхүүний чанарт өөрчлөлт гарснаар экосистемд ямар сөрөг нөлөөлөл үзүүлэх вэ?	Экосистемд аюултай

Хүснэгт 3.1.2 Байгаль орчин, экологид үзүүлэх нөлөөлөл, хоруу чанар

№	Химийн бодисын нэр, CAS дугаар	Байгаль орчин, экологид үзүүлэх нөлөөлөл	Хоруу чанар
1	Аммонийн нитрат NH_4NO_3 CAS: 6484-52-2	- Аммонийн нитрат нь азотын эрдэс бордооны найрлагад ордог хэдий ч хөрсөнд хаягдсан тохиолдолд хөрсний чанарт сөрөг нөлөө үзүүлэн нитрат хуримтлагдахад хүргэнэ. -Аммонийн нитратын найрлага дах аммонийн ионууд ($-\text{NH}_4$) ургамалд түргэн шингээх чадвартай. Нитрат ионууд ($-\text{NO}_3$) хөрсөнд хуримтлагдаж, хөрсний чийгтэй хамт ууршихад ургамлын навчийг түлж гэмтээдэг. - Биоаккумуляцийн потенциал н-октанол/ус ($\log \text{KOW}$) = -3.1 (бага хэмжээгээр хуримтлагддаг) -Усан орчинд бага зэрэг хортой	Байгаль орчинд үзүүлэх хоруу чанар: Загасанд үзүүлэх хоруу чанар: LC50, 447 мг/л, 48 цагт Дафни болон бусад сээр нуруугүй амьтдад үзүүлэх хоруу чанар: EC50, 555 мг/л Байгаль орчинд үзүүлэх хоруу чанар: Загасанд үзүүлэх хоруу чанар: LC50, 74 мг/л, 48 цагт Дафни болон бусад сээр нуруугүй амьтдад үзүүлэх хоруу чанар: EC50, 555 мг/л
2	Натрийн нитрат NaNO_3 CAS: 7631-99-4	-Усан орчинд хортой бодист хамаарахгүй -Азотын эрдэс бордооны найрлагад ордог боловч хөрсөн хаягдсан тохиолдолд хөрсний тэнцвэрийг алдагдуулна.	Байгаль орчинд үзүүлэх хоруу чанар: Загасанд үзүүлэх хоруу чанар: LC50, 1000 мг/л 96 цагт Дафни болон бусад сээр нуруугүй амьтдад үзүүлэх хоруу чанар: LC50, 1000 мг/л
3	Дизелийн түлш CAS 64742-47-8	-Усны амьд организмд аюултай нөлөөлөл удаан хугацаанд үзүүлнэ. Усны гадаргуу дээр нимгэн давхарга үүсгэн усны амьд организмыг үхүүлнэ - Усны амт, чанарыг муутгана - Найрлага дах дэгдэмхий нүүрстөрөгчит нэгддүүд агаарт ууршиж, агаар орчныг бохирдуулна - Хөрсийг хордуулан, тэнцвэрийг алдагдуулж, ургамал ногоог үхүүлнэ. Хөрсөөр нэвчин усыг бохирдуулна. Хөрснөөс уурших хурд багатай - Биоаккумуляци үүсгэнэ	Байгаль орчинд үзүүлэх хоруу чанар: Загасанд үзүүлэх хоруу чанар: LC50, 2.4 мг/л – 96 цагт, Дафни болон бусад сээр нуруугүй амьтдад үзүүлэх хоруу чанар: LC50, 4,720 мг/л- 96 цагт

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь “Пи Эй Ар Эй Эн” ХХК-ийн

Баян-Ус хүрэн нүүрсний орд газар дахь ил уурхайн үйл ажиллагаанд байгаль орчны
нийцлийг хангуулах гол зорилготой.

Төлөвлөгөөний хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорилт болгоно. Үүнд:

- ✓ Байгаль орчны аудит, БОННУ-ний шаардлагуудыг биелүүлэх:
- ✓ Компанийн стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах:
- ✓ Гэрээт байгууллагуудын байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг
тодорхойлж, түүний гүйцэтгэлд хяналт тавих, аргазүйн зөвлөгөөгөөр хангаж
ажиллах:
- ✓ Уурхайн үйл ажиллагааны талбайн хүрээнд байгаль орчны хуулийн нийцлийг
хангуулахад анхаарч ажиллах:
- ✓ “Пи Эй Ар Эй Эн” ХХК-ийн уурхайн хэмжээнд байгаль орчны бодлого, дүрэм, журмыг
хэрэгжилтийг хангах:
- ✓ Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж,
байгууллагын газар ашиглалтын байдалд хяналт тавьж төрийн болон хяналтын
байгууллагуудад мэдээ хүргэх:
- ✓ БОМТ-нд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх байгаль орчны
асуудлыг тодорхойлох:
- ✓ ОХШХ-нд талуудын оролцоог хангах, ил тод нээлттэй байх зарчмыг баримтлах:

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

5.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Агаар орчин						
Хөрс хуулах, хөрс, нүүрс ачиж буулгах, тээвэрлэх тэсэлгээ хийх зэрэг нь орчны агаарыг тоосоор бохирдуулах эх үүсвэр болдог. Уурхайд тэсэлгээ хийх, машин техникийн хөдөлгүүрээс гарах утаанд угаарын хий (CO), азотын дутуу исэл (N ₂ O), хүхэрлэг хий (SO ₂), хүхэрт устөрөгч (H ₂ S) зэрэг хорт хий ялгарна. Эдгээр хийнүүд зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд төрөл бүрийн хордлого үүсгэнэ.	Агаарын чанарыг тогтмол хянах, хэмжих	Ил уурхай	ОХШХ-т тусгав.		Төсөл хэрэгжих хугацаанд	- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5002:2000 - Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS5850:2008 - Агаар мандал. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага MNS 3384:1982 - Агаар мандал. Бохирдлын эх үүсвэр, нэр томъёоны тодорхойлолт MNS 3383:1982 - Агаарын чанар. Хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063:2010 - Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016
	Тээвэрлэлтийн бусад зам, нүүрс ачих цэгүүдийн талбай, түүний ойр орчмыг байнга усалж, чийгтэй байлгах арга хэмжээ авах.		Үйл ажиллагааны дотоод төлөвлөлтөөр		Хуурайшилт ихтэй хавар намрын улиралд	
	Хорт хий гарах нөхцөлтэй газруудад байнгын ажиглалт, хэмжилт хийж, хяналт тавьж байх	Ил уурхай	ОХШХ-т тусгав.		Төсөл хэрэгжих хугацаанд	
	Хорт хий гарч болзошгүй ажлын байранд ажиллагсдыг хошуувч, баг зэрэг шаардлагатай хамгаалах хэрэгслээр хангана.	Хорт хийнд өртөж болзошгүй нийт ажилчдад	300.0	30,000.0	2025 он	

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
						- Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) - Амьсгалын замыг хамгаалах хэрэгсэл /Хошуувч, шүүлтүүртэй баг, тусгаарласан агаартай бүтэн баг/, MNS 5620:2006
Тоног төхөөрөмж, автомашины үйл ажиллагааны явцад агаар орчинд хорт хийн ялгарал үүсгэх	Ил уурхайд ашиглагдаж буй хүнд даацын тээврийн хэрэгслүүдэд оношлогоог тогтмол хийлгэж, тэдгээрт засвар үйлчилгээ хийж түлшний зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх	Ил уурхайд ашиглах 66 машин механизмууд	30.0	9900.0	Жилд 1 удаа тогтсон хугацаанд /Улсын үзлэгт/ Жилд 4 удаа /дотоод/	- Зам, тээврийн сайдын 2013 оны 232 дугаар тушаал, “Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах журам” - Засгийн Газрын 2016 оны 213 дугаар тогтоол - Бензин хөдөлгүүртэй автомашин- Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5013:2003 - Дизель хөдөлгүүртэй автомашин- Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Хөрсөн бүрхэвч						
Хөрсөн бүрхэвчийн эвдрэл	Шимт хөрсийг хуулж авах. Хуулалтын зузааныг гадаргын налуу ихтэй нимгэн хөрстэй газарт 30 см, налуу багатай тэгшивтэр газарт 50-60 см байхаар тооцно. Нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн газруудад стандартын дагуу нөхөн сэргээлт хийх	Ил уурхайн бүсэд	ТЭЗҮ-д тусгагдсанаар	ТЭЗҮ-д тусгагдсанаар	Уурхайн ашиглалтын явцад	- Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008 , - Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS 5917:2008, - Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2023
Шимт хөрсний бүтцийн алдарал	Хуулж авсан болон шинээр хуулж хадгалах шимт хөрсийг нөхөн сэргээлтэнд ашиглахаас бусад тохиолдолд олон дахин байршлыг сольж зөөхгүй байхаар тооцож хадгалах талбайг сонгох	Ил уурхайн бүсэд	ТЭЗҮ-д тусгагдсанаар	ТЭЗҮ-д тусгагдсанаар	Уурхайн ашиглалтын явцад	- Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008 , - Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS 5917:2008, - Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага MNS

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
						5918:2023
Тэсэлгээний үед үүссэн тоосонцорын нөлөөгөөр хөрсний гадаргад үүсэх болзошгүй бохирдол	Ил уурхайн бүсэд байгааа ердийн хөрсний өнгөн үе давхаргад (0-5 см) тогтмол мониторинг хийж байх	Тоос буух боломжтой 2-3 цэгт	-	ОХШХ-т тусгав.	Уурхайн ашиглалтын явцад	Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019
Техник тоног төхөөрөмжийн эвдрэлээс үүдэлтэй тос, масло гэх мэт шатах тослох материалын болзошгүй цэгэн бохирдол	Тос, тослох материал асгарсан тохиолдолд шингээж авах, цэвэрлэх элс, хүрз гэх мэт материал багаж хэрэгсэлийг байнга бэлэн байлгах, хэрвээ их хэмжээний (100 л дээш) асгаралт үүсээд цэвэрлэсний дараа хөрсний органикийн шинжилгээ хийж хянах	Тухайн цэг болон талбай	-	Осол эрсдэлийн үед ашиглах төсвөөс	Эрсдэл үүссэн тухайн үед нэн даруй	
Усан орчин						
Жилд ихээхэн хэмжээний усыг шүүрүүлж байгаа нь уурхайн орчны гадаргын болон хөрсний усны түвшин буурахад нөлөөлж, улмаар хөрсөнд тодорхой хэмжээгээр хуурайшилт үүснэ.	Уурхайн ойр орчмын нутаг дэвсгэрийн уст давхаргын үзүүлэлтэд байнга хяналт тавьж байх, уурхай орчимд цооногийн түвшинг тогтмол хянах;	Ил уурхайн бүсэд	Дотоод төлөвлөлтөөр		Уурхайн ашиглалтын явцад	Байгаль орчныг хамгаалах тухай хууль MNS 6148 - 2010 Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Шүүрлийн усны чанар	Байнгын хяналт шинжилгээ хийж байх.	Шүүрлийн усанд	ОХШХ-т тусгав.			Байгаль орчныг хамгаалах тухай хууль MNS 6148 - 2010 Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Овоолгын хүчиллэг урсацыг хянах, урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.						
Шавхан зайлуулах усан дээр тоолуур суурилуулах	Байнгын нарийвчлалттай тоо бүртгэлтэй байх		Шавхан зайлуулалт хийгдэхгүй	2025 онд	Усны тухай хуулийн 30.1.4-р зүйл	
Ургамлан нөмрөг						
Ургамлан нөмрөг устгах, доройтох	Биологийн нөхөн сэргээлтийн талбайг нэмэгдүүлэх	Төслийн хүрээнд	Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөөнд тусгав.		Үйл ажиллагааны турш	- БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-138 дугаар тушаалын хавсралт “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал” - Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2023
	Нөхөн сэргээлтийн үр дүнг стандартад хүргэхэд хяналт тавих					

Цацраг идэвхи						
Цацрагийн нөлөөллөөс хамгаалах, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангах	Цацрагийн хамгаалалтын сургалтад уурхайн ажилчдыг хамруулах	Үйл ажиллагааны турш	2025 хийгдэхгүй. Үйл ажиллагаа эхлэх үед хийгдэн. Нүүрс гаргалт 2026 онд төлөвлөж байгаа.		Төслийн хугацаанд	Цөмийн энергийн комиссын 2016.02.16-ны өдрийн 01 дугаар тогтоолын хавсралт Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм
	Радон хий хэмжих багаж түрээслэх					
Цацрагийн төвшинг хэмжих	Уурхайн овоолго, нүүрсэнд	Тухай бүрт				
Удирдлага, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ						
Хүний эрүүл мэнд	Ажиллагсдыг тусгай хувцас хэрэгслээр ¹ бүрэн хангах	Бүх ажиллагсад	Аж ахуйн нэгж байгууллага эрсдэлийн төвшнөөс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулна.		Ажилтан бүрийг тусгай хувцас хэрэгслээр тогтмол хангах.	- Монгол Улсын Их Хурлын 2015 оны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 5/26 дугаар зүйлийн 26.2 хэсэг - Хөдөлмөрийн тухай хууль - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль - Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй
	Ажиллагсдыг эмнэлгийн нарийн мэргэжлийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	Бүх ажиллагсад			Жилд 1 удаа	
	Нэг бүрийн хамгаалах хэрэгслээр ² хангах	Төслийн хүрээнд			Үйл ажиллагааны туршид	
Хөдөлмөрийн аюулгүй байдал	Химийн бодистой шууд харьцаж ажилладаг ажиллагсдыг үйлдвэрлэлийн багаж	Бүх ажиллагсад	500.0	50,000.0	Жилд 1 удаа	

¹ “Тусгай хувцас” гэж үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс ажилтныг хамгаалах зориулалт бүхий хувцас, гутал, малгай, бээлий зэрэг хэрэгслийг хэлнэ.

² “Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл” гэж үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс ажилтныг хамгаалах зориулалт бүхий хэрэгслийг хэлнэ.

	хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй ажиллах, тэдгээрийг ашиглах дадал эзэмшүүлэх болон аюулгүй ажиллагааны сургалтанд тогтмол хамруулж, мэдлэгийг шалгаж байх					ажиллагааны ерөнхий шаардлага MNS 4992:2000 - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг MNS 5029:2011 - Хамгаалалтын хувцас ерөнхий шаардлага. MNS (ISO) 13688:2000 - Гал түймрээс хамгаалах. MNS 5566-2005 - Тусгай зориулалтын ажлын хувцас. Ерөнхий шаардлага MNS 6231:2011
	Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах, гал түймэр, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулах	Бүх ажиллагсад	Дотоод төлөвлөлтөөр		Тогтмол	
Төслөөс байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл	Байгаль орчны аудит хийлгэх	Төслийн хүрээнд	2026 онд хийгдэн		2 жил тутамд 1 удаа Байгаль орчны аудит хийх эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10-р зүйл.
	Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах	“Пи Эй Ар Эй Эн” ХХК	2026 онд барилга байгууламж болон уурхай комист хүлээлгэж өгөх үед хийгдсэн байна.		2 жил тутамд 1 удаа Дорнод аймгийн Онцгой байдлын газар	Галын аюулгүй байдлын тухай хууль Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журам
	Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд дүгнэлт гаргуулах	Үйл ажиллагааны дотоод төлөвлөлтөөр	2026 онд үйл ажиллагаа жигдрэхэд хийгдэн. 2025 онд төслийн талбайд байнгийн ажиллах хүч байрлахгүй.		2026 онд эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.	- Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/74 дүгээр тушаал - Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 дугаар тушаал, Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн

					үнэлгээ хийх журам - Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ, MNS 5080:2001 - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015
	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг хангах, биелэлтийг тайлагнах	“Пи Эй Ар Эй Эн” ХХК	Байгууллагын дотоод төлөвлөлтөөр	Жил бүр	- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам
СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НИЙТ ЗАРДАЛ /мян.төг/				176,420.0	
Тухайн жилийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал /мян.төг/				880.0	

5.2 Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах төлөвлөгөө

5.2.1 Тоос бууруулах төлөвлөгөө

Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх гол агаар бохирдуулагч нь тоос тоосонцор юм. Ил уурхайгаас нүүрс олборлохын тулд их хэмжээний хөрс чулуулгийг хуулж зөөвөрлөх шаардлагатай байдаг ба энэ үйл ажиллагаанд ашиглагдах экскаватор, ачигч, зөөврийн ачааны машин эсвэл туузан дамжуурга зэрэг машин тоног төхөөрөмжийн үйл ажиллагаанаас их хэмжээний тоос тоосонцор үүсдэг. Мөн идэвхтэй овоолго, эвдрэлд орсон талбай, нүүрсний овоолго зэргээс хуурай салхитай үед тоос шороо агаарт дэгдэж салхины дагуу тархдаг. Уурхайн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг үнэлэхэд уурхайн бүс дэх тоос үүсгэх эх үүсвэрийг тодорхойлж тэдгээрээс үүсэх тоос тоосонцрын хэмжээг тогтоох нь чухал юм. Энэ нь агаарын бохирдлыг бууруулах зохимжтой арга хэмжээнүүдийг төлөвлөхөд ихээхэн ач холбогдолтой.

Нүүрсний уурхайн үйл ажиллагаанаас үүсэх тоос тоосонцрын хэмжээг АНУБХА-AP42 (USEPA AP42) гарын авлагад тусгагдсан нүүрсний ил уурхайгаас үүсэх тоосонцрын хаягдлын факторуудыг ашиглан тооцоолсон. Уурхайн дотоод тээврийн зам дээрх тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нь тоосжилтын хамгийн гол эх үүсвэр бөгөөд хаягдал чулуулаг тээвэрлэлтэд 90 тн даацтай автосамосвал, нүүрс тээвэрлэлтэд 55 тн даацтай автосамосвал ашиглагдах ба замуудаас үүсэх тоосжилтын хэмжээг тооцохдоо ашиглалтын хугацаанд замаас үүсэх нийт тоосыг байгалийн хүр тунадас болон усалгаагаар 70% бууруулна гэж үзсэн.

5.2.2 Уурхайн ашиглалтын замыг сайжруулах

Уурхайн дотоод тээврийн зам дээрх тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нь тоосжилтын хамгийн гол эх үүсвэр болдог. Хаягдал чулуулаг тээвэрлэлтэд 90 тн даацтай SANY-SRT95C, нүүрс тээвэрлэлтэд 55 тн даацтай Sinotruk ZZ5707V4048CJ автосамосвалууд ашиглагдах ба уурхайн карьер доторх гол замуудаас тоосжилтын хэмжээг тооцохдоо ашиглалтын хугацаанд замаас үүсэх нийт тоосыг байгалийн хүр тунадас болон усалгаагаар 70% бууруулна гэж үзсэн. Уурхайн хаягдал шорооны овоолго хүртэлх зай ашиглалтын жилүүдээр 4.0-6.4 км, нүүрс хүлээн авах талбай хүртэлх зай мөн ашиглалтын жилүүдээр 1.3-1.4 км байна.

5.2.3 Уурхайн зам талбай, нүүрсний агуулах, гаалийн талбайд усалгааны машиныг тогтмол ажиллуулах

Уурхайн хэмжээнд тогтмол усалгааны машин жилийн турш тогтмол ашиглаж ажиллана.

5.2.4 Уурхайн дотоод зам талбайд шороо зам дээгүүр зорчиж буй тээврийн хэрэгсэлд хурдны хязгаар тогтоож гэнэтийн хэмжилт шалгалт хийж хяналт тавих.

Сар бүр уурхайн хөдөлгөөнт техникуудад хяналт шалгалтыг Уурхайн Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэнүүдийн хамтаар тогтмол хийж гүйцэтгэн бүртгэл хөтлөж зөвшөөрөгдсөн хэмжээнээс хурдыг хэтрүүлсэн ажилтнуудад арга хэмжээ авч

нийтэд мэдээлэх байдлаар хурдны хязгаарыг байнга мөрдүүлж ажиллана.

5.2.5 Нүүрс тээвэрлэлтийн машинуудын хяналт

Нүүрс тээвэр, ложистикийн хэлтэстэй хамтран нүүрс тээвэрлэлт хийж буй машинуудыг бүтээлэгтэй байлгаж, зөвшөөрөгдсөн замын маршрутын дагуу тээвэрлэлт хийж байгаа эсэхэд тогтмол хяналт хийж ажиллана

5.2.6 Ашиглаж буй техник хэрэгслүүдийг автотээврийн хяналтын үзлэгт оруулах

Үйлдвэрлэл техникийн газрын Засвар механикийн хэлтэстэй хамтран уурхайн ажилд ашиглагдаж буй автомашинуудыг тээврийн хэрэгслийг жилд нэг удаа тогтсон хугацаанд үзлэгт хамруулах ажиллана. Мөн дотооддоо техникийн үзэг шалгалтыг хуваарь гаргаж долоо хоног бүр хамруулж, утаа их хаядаг, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гаргахгүй байх дээр хяналт тавьж ажиллана.

5.2.7 Агаарын чанарын хяналт

Үйл ажиллагаа эхэлсэн тохиолдолд. Агаарын чанарын суурин 1 ширхэг станцны худалдан авалтыг хийж, Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт дүн мэдээг онлайнаар өгч ажиллана

5.3 Усан орчинд учруулах нөлөөллийг багасгах төлөвлөгөө

5.3.1 Газар доор усны бохирдлоос хамгаалах

Газар доорх усны бохирдол үүсэхээс хамгаалж худгийн хийц, хамгаалах байр, тоноглолд тусгай шаардлага тавьж хяналттай байлгана.

Худгуудад байршуулсан усны тоолуур гэмтэх, эвдрэх, тоолуурын гэрчилгээний хугацаа дууссан тохиолдолд сумын Байгаль орчны улсын байцаагчид мэдэгдэж, түүний хяналтан дор лацыг хөндөж, засвар үйлчилгээг хийх, стандарт хэмжилзүйн газраар баталгаажилт хийлгэсэн тоолуурыг суурилуулна. Ус ашиглагч болон байгаль орчны улсын байцаагч нарыг байлцуулан акт үйлдэж баталгаажуулсан байна. Засвар үйлчилгээ хийх явцад худгаас зайлшгүй ус авч ашиглах тохиолдолд усны машины рейсийг үнэн зөв бүртгэж сар бүрийн усны актад тусгана.

5.3.2 Ус ашиглуулах дүгнэлт гаргуулж, ус ашиглах гэрээ байгуулах, төлбөрийг тогтмол хугацаанд төлөх

Ус ашиглах дүгнэлтийг гаргуулж дүгнэлтэнд заагдсаны дагуу холбогдох гэрээг байгуулж төлбөрийг сар бүрийн тоолуурын заалтыг сумын байгаль хамгаалагчаар баталгаажуулж төлбөрийг тогтмол хугацаанд нь төлсөн байна

5.3.3 Хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ байгуулан төлбөр төлөх

Цэвэрлэх байгууламжаас гарч буй цэвэршүүлсэн бохир ус нь стандартад нийцэж байгаа эсэхийг улирал тутамд хянаж, итгэмжлэгдсэн лабораторид усны дээжийг шинжлүүлэх ба шинжилгээний дүнд үндэслэн уурхайн зам талбайн тоосжилт дарах, мод услахад ашиглана

5.4 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөө

5.4.1 Нүүрс ус төрөгчийн хяналтгүйгээс хөрс бохирдох

Уурхайд технологийн горим алдагдах зэрэг шалтгаанаар асгаралт түгээмэл тохиолддог. Нүүрс-устөрөгчийн болон химийн бодисын удирдлагын тогтолцооны хүрээнд асгаралтын иж бүрдэл байршуулж асгаралтын үед авах арга хэмжээг мөрдөж ажиллана. Асгаралтын үр дагаврыг багасгах, сэргийлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Ажлын байрны үзлэг болон техникийн тойрох үзлэг шалгалтаар асгаралт үүсэх өндөр магадлалтай техник төхөөрөмж, объектуудад урьдчилсан үзлэг хийж хариу арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлнэ.
- Асгаралт гарсан тохиолдолд нөлөөллийг хязгаарлах, орчин тойрныг бохирдуулахгүй байхад бэлэн байх нөхцөлийг хангаж асгаралтын иж бүрдлийг бэлэн байлгана.
- Саармагжуулах бодисын бэлэн байдлыг бэлэн байлгах, асгаралт үүсч болзошгүй засварын төв зэрэг барилгуудад асгаралтын иж бүрдлийн бэлэн байдлыг нөөцлөх шаардлагыг чандлан мөрдөнө.
- Асгаралт үүссэн тохиолдол бүрийг бүртгэж цаашид ямар арга хэмжээ авснаар илүү үр дүнтэй байх дүгнэлт боловсруулж суралцан хөгжих тогтолцоог хэрэгжүүлнэ

5.4.2 Технологийн горимын мөрдөлтийг хангуулах ажиллагаа

Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгын технологийн горимыг хангуулж байгаль орчны чиглэлийн дотоодын журам, горимуудыг мөрдөнө.

- Уурхайн хэмжээнд Ажлын байрны үзлэгийг тотмол хугацаанд хийж аливаа үл нийцлийг илрүүлж арилгах хариу арга хэмжээ авна

5.5 Газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

5.5.1. Зөвшөөрөлгүй газар хөндөхөөс сэргийлж, аливаа газар хөндөх ажлыг эхлүүлэхээс өмнө газар хөндөх зөвшөөрөл олгох, хөндөгдсөн газрын бүртгэлийг мэдээллийн санд оруулах

Газар хөндөх зөвшөөрлийг баталсан журам, зохион байгуулалтын дагуу хэрэгжүүлэн, газар хөндөх зөвшөөрлийн үйл явцад сайжруулалт хийж газрын хэмжээг GIS систем болон нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

5.5.2. Тусгай зөвшөөрөлгүйгээр түгээмэл тархацтай ашигт малтмал, ус, ургамал ашиглахгүй байх, хяналт хийх

Холбогдох зөвшөөрөлгүйгээр түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахгүй байлгах үүднээс Уурхайн гадаад бүсэд байгаль орчны нийцлийн хяналт хийх журам дагуу тогтмол хяналт хийнэ.

5.6 Ургамлан нөмрөгт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах

Монгол улсын хэмжээнд байгалийн жамаар нөхөн сэргэх, чадваргүй, тархац нэн хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй устах аюулд орсон 133 зүйлийн нэн ховор ургамал, байгалийн жамаар нөхөн сэргээгдэх чадавх нь хязгаарлагдмал, нөөц багатай устаж болзошгүй 355 зүйлийн ховор гуурст дээд ургамал бүртгэгдсэн байдаг. Монгол орны ургамлын аймагт 1000 орчим зүйлийн эмийн, 200 гаруй хүнсний, 200 орчим техникийн 150 гаруй витаминт, 200 гаруй будагт, 100 орчим чимэглэлийн, 1000 гаруй тэжээлийн ач холбогдолтой ашигт ургамал байдаг.

- Тусгай зөвшөөрлийн талбайд олборлолтонд өртөх талбайн нэн ховор, ховор ургамлын тархацын судалгааг хийж, координат цэгийг тэмдэглэх;
- Фото зургаар баталгаажуулан, ургамлын хамтаамал бэлтгэх

5.7 Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө

Уурхайн үйл ажиллагааны шууд болон дам нөлөөллөөр биологийн олон янз байдалд өртөх эрсдэлээс хамгаалах аргыг тодорхойлохын тулд өртөлтийн судалгааг сайтар хийсэн байх шаардлагатай. Мониторингийн хөтөлбөрөөр экологийн ач холбогдолтой амьтны аймгийн гол хүрээний зүйлүүдийн тооллого, судалгааг дотоод бололцооны дагуу хийж Гүйцэтгэхээр төлөвлөж байна.

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025-2028 онд биологийн нөхөн сэргээлт хийх төлөвлөгөө байхгүй бөгөөд Уурхайн хаалт хийсний дараа 167.2 га талбайд нөхөн сэргээлт хийгдэнэ. Нөхөн сэргээлтийн нийт зардал 1.7 тэрбум төгрөг байхаар тооцооллоо.


7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА

Дүйцүүлэн хамгаалж буй газрын урт хугацааны хамгааллыг хангах: Дүйцүүлэн хамгаалахаар сонгон авсан газарт биологийн олон янз байдалд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй ашигт малтмалын хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл олгох гэх мэт хөгжлийн үйл ажиллагаа, бусад сөрөг нөлөөлөл бүхий газар ашиглах зөвшөөрлийг давхардуулан олгохгүй байх үүднээс уг газрыг дүйцүүлэн хамгааллын түршид хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Дүйцүүлэн хамгааллыг хэрэгжүүлэхээр сонгон авсан газрыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах асуудлыг зохих шатны төрийн байгууллагууд шийдвэрлэнэ.

Дээрх шаардлагуудыг хангахын тулд Экологийн бүс нутгийн үнэлгээний мэдээллийг ашиглан нөлөөлөлд өртсөн газартай ижил төстэй экосистем бүхий газрыг сонгоно. БОНХЯ-ны сайдын А-117 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу ТНС байгууллагаас боловсруулсан дүйцүүлэн хамгааллыг тооцоолох программ дээр төслийн нөлөөлөлд өртсөн талбайн мэдээлэл бүхий өгөгдлийг оруулан тооцоолоход:

- Матад сумын нутагт 5 газар /Жаран тогооны тал, Мэнэгийн цагаан хоолой, Жаргалантын адгын худаг, Дорнод Монгол, Дорнод Монгол өргөтгөл/
- Дорнод аймгийн нутагт 11 газар
- Зүүн бүс дэх Экологийн бүсэд 44 газар тодорхойлогдсон байна.

Зураг 4.1. Дүйцүүлэн хамгааллыг хэрэгжүүлж болох газрууд, түвшин бүрээр



үүсвэр: БОННУ-ний зөвлөх баг, 2024 он

Дээрх тодорхойлсон газруудаас төслийн талбайтай байршлын хувьд хамгийн ойр, биологийн олон янз байдалтай экологийн хувьд дүйцэхүйц байх шаардлагыг хангаж буй гэж үзэж Жаран тогооны тал хэмээх аймгийн ТХГН-ийг сонгон авлаа. Тус ОНТХГН-ыг 2014 онд ой, амьтан, ургамал, усны нөөцийг хамгаалах зорилгоор ТХ-д авчээ.

Тус газарт дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд зэрлэг амьтдыг хамгаалах биотехникийн арга боломж бололцоо судлагаа. Сум орон нутаг иргэдтэй уулзалт хийх. Дүйцүүлэн хамгаалах орон нутгийн аж ахуй нэгжийг судлах, гэрээ хэлэлцээр хийх ажлуудыг төлөвлөж байна. Дүйцүүлэн хамгаалал хийгдэх газрын биологийн олон янз байдлын суурь судалгаа хийлгэх зэрэг ажлуудыг төлөвлөлөө.

Төслийн үргэжлэх хугацаанд нийт дүйцүүлэн хамгаалах шаардлагатай 4246 га талбайн судлагаа хийхэд жилд **1,500,000** төгрөгийг дүйцүүлэн хамгааллын төлөвлөгөөнд зарцуулахаар байна.

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслөөс орон нутгийн иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллагыг нүүлгэн шилжүүлэх шаардлагагүй.

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ

Төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих орчны түүх, соёлын өв дурсгалд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.

10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн химийн бодисын эрсдэлийн үнэлгээний дүнд тогтоосон аюултай болон хортой химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг энд тусгасан.

Хүснэгт 1 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Болзошгүй осол						
Химийн бодис хадгалах хадгалалтын горим алдагдах	Ажилтнуудыг химийн бодисын хор аюул, түүнтэй хэрхэн харьцах, асгарч, алдагдсан үед авах арга хэмжээ, хувийн хамгаалах хэрэгсэл, анхны тусламж, галын аюулын үед авах арга хэмжээний талаар сургалтанд хамруулах	Химийн бодистой харьцаж ажилладаг бүх ажилчид	500.0	25,000.0	Жилд 1 удаа	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг MNS 5029:2011
Шингэн хаягдлын сав баглаа боодол задарч, асгарах	Химийн бодисын сав баглаа боодлыг тогтмол шалгах	Төслийн хүрээнд	-	-	Шатамхай, онцгой хортой бодисын сав баглаа боодлыг өдөрт 1 удаа, бусад бодисынхыг долоо хоногт 1 удаа	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг MNS 5029:2011
	Өөр саванд савлах бол химийн бодист тэсвэртэй материалаар хийсэн зориулалтын саванд савлах		-	-	Тухай бүрт	
	“Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн		-	-		

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг. MNS 5029 : 2011” стандартад заасан хаяг шошго наах					
Хортой хий хуримтлагдах	Агуулахын агааржуулалтын системийн засвар үйлчилгээг тогтмол хийх	Төслийн хүрээнд	Үйл ажиллагааны дотоод зардал		Үйл ажиллагааны явцад тогтмол хийх.	“Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага. MNS 6458:2014”
Санамсаргүй байдлаас химийн бодисын бүрэн бүтэн байдал алдагдаж, асгарах	Химийн бодисын сав баглаа боодлын битүүмжлэлийг тогтмол шалгах	Төслийн хүрээнд	-	-	Өдөр бүр	“Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам” – Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 54/A/136/A/125 дугаар хамтарсан тушаал.
	Химийн бодистой харьцаж ажилладаг ажилчдад зааварчилгаа өгөх	Химийн бодистой харьцаж ажилладаг бүх ажилчид	-	-	Өдөр бүр	
Гал түймэрГал түймэр						

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Гал түймэр	Гал түймэртэй тэмцэх багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж авах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний тоноглолуудыг зохих газарт байнга бэлэн байлгах	Ил уурхайн хэмжээнд	300.0	15,000.0	Үйл ажиллагааны туршид, жил бүр	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг MNS 5029:2011
Цахилгааны гэмтэл, богино холболт үүсэх	Цахилгааны монтаж, гэрэлтүүлгийн бүрэн бүтэн байдал, ажиллагааг тогтмол хянаж байх, гэмтэл гарсан тохиолдолд түргэн шуурхай засварлах	Төслийн хүрээнд	-	-	Өдөр бүр	“Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага. MNS 6458:2014”
	Ус, чийгнээс хамгаалсан хамгаалалт хийх	Төслийн хүрээнд	Үйл ажиллагааны дотоод зардал			
Машин механизмаас хорт хий ялгарах	Машин механизмаас гарах хорт хийн ялгаралтыг бууруулах шүүлтүүр суурилуулах	Төслийн хүрээнд	300	30,000.0	2025 онд	Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4598:2011

Тусгай зөвшөөрөл эзэмшигч: “Пи Эй Ар Эй Эн” ХХК

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-015616

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ /мян.төг/				69,286.0		
Тухайн жилийн осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал /мян.төг/				1,100.0		

11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн бүхий л үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлаас хүний эрүүл мэнд болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах зорилгоор хог хаягдлын зохистой удирдлагыг хэрэгжүүлэхэд төлөвлөгөөний зорилго оршино. Хүний амьдрах орчин, эрүүл мэндэд учруулах хог хаягдлын сөрөг нөлөөг илрүүлэн зохих арга хэмжээ авахад хэрэглээ, бүтээгдэхүүний сонголтыг харгалздаг дэлхий нийтийн хандлага бий болж байгаад анхаарна.

Энэхүү хог хаягдлын менежментийн төлөвлөгөө нь “Пи Эй Ар Эй Эн” ХК-ийн төслийн бүхий л үйл ажиллагаанаас гарч буй бүх төрлийн хог хаягдалд хамаарна. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг энэхүү төслийн талбай дээр үйл ажиллагаа явуулж буй үндсэн болон гэрээт байгууллагууд дагаж мөрдөх үүрэгтэй.

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Үйлдвэрийн хог хаягдал Хүний эрүүл мэндэд сөрөг	Хог хаягдлын зэрэглэлийг тогтоолгох	Ил уурхай	150.0	15,000.0	Жил бүр	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/349 дугаар
	Хог хаягдлын тооллого хийж, эх үүсвэр тус бүрээс жилд үүсэх хаягдлын төрөл, тоо хэмжээг нарийвчлан тогтоох				Жил бүр	

Тусгай зөвшөөрөл эзэмшигч: “Пи Эй Ар Эй Эн” ХХК
 Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-015616

нөлөөлөх	Химийн бодисын сав баглаа, хаягдлыг их хэмжээгээр хуримтлуулж удаан хугацаагаар хадгалахгүй байх, үйлдвэрээс зохих журмын дагуу материалыг бүрдүүлж хаягдлыг устгуулах тухай хүсэлтийг гаргаж байх		-	-	Жил бүр	тушаал Хог хаягдлын тухай хууль Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/368 дугаар тушаал
	Үйл ажиллагаанаас үүсэх аюултай хог хаягдлыг /авто тээврийн хэрэгслээс гарах аюултай хог хаягдал/ устгах, аж ахуйн нэгжид шилжүүлэх хүртэл түр хадгалах зориулалтын, стандартын шаардлага хангасан агуулахтай зураг төсөл боловсруулах.	Ил уурхай	500.0	10,000.0	2025 онд	Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага. MNS 6458:2014
	Тээврийн хэрэгслийн аккумулятор, ажилласан тос зэрэг дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг холбогдох журмын дагуу цуглуулж, дахин боловсруулах үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж компаниудтай гэрээ байгуулан хүлээлгэж өгөх		Үйл ажиллагааны төлөвлөлтөөр		Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журамд заасан хугацаанд	Хог хаягдлын тухай хууль Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам
ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ /мян.төг/					24,746.0	
Тухайн жилийн хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал /мян.төг/					650.0	

11.1 Аюултай хог хаягдал

11.1.1 Хаягдал тосны байгууламжийг стандартын дагуу байгуулах

Нэг цэгт төвлөрүүлэн стандартын дагуу байгуулсан байна. Хөрсөнд тос масло алдагдахаас сэргийлж бетонон суурьтай, халиагууртай хийх талбай суурь бэлтгэх. 2026 он олборлолт эхлэх үе зутгалт хийнэ.

11.1.2 Аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй ААН-д шилжүүлэх.

Эмнэлгээс үүсдэг хэрэглэгдсэн тариур, тариурын зүү, дуслын систем, хэрэгсэл, бохирдсон боолт, биеийн хэсэг, оношлогооны дээж, цус, химийн бодис, эм, эмнэлгийн багаж, цацраг идэвхт материалыг багтаана. Эдгээр хог хаягдлыг сум дундын эмнэлэгт хүргэж тусгай цэгт устгуулна.

Аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй хог хаягдал устгах эрхтэй аж ахуйн нэгжид шилжүүлнэ. Техникийн тос материалаар бохирдсон шингээгч материал, алчуур, тосны шүүр, түлш, техникийн тосоор бохирдсон хөрс, химийн бодисын сав баглаа, боодлууд энэ ангилалд багтана.

11.1.3 Гэрээт байгууллагуудын авуултай хог хаягдлын талбай стандартыг хангуулахад хяналт тавих

Аюултай хог хаягдлын ангилан ялгалт, хадгалалтын стандартыг нийт уурхайн хэмжээнд мөрдүүлнэ. Гэрээт байгууллагууд туслан гүйцэтгэгчдэд тавих хяналтыг өргөжүүлэх зорилгын хүрээнд ажиллахыг уриалж шаардлага тавьж ажиллана.

Аюултай хог хаягдлыг төвлөрүүлэх байгууламжуудад дараах объектууд хамаарна.

Үүнд:

- Ашигласан тос төвлөрүүлэх байгууламж, талбай
- Ашигласан тосны шүүр, бохир алчуур, асгаралт шингэсэн материал цуглуулах талбай

- Бохир хөрс саармагжуулах талбай
- Ашигласан аккумулятор төвлөрүүлэх талбай

11.2 Ахуйн хог хаягдал

11.2.1 Уурхайн хог хаягдлын түр цэг тогтоолгож, хашлага хамгаалалт хийж тэмдэгжүүлэх

Уурхай болон кемпийн хог хаягдал түр хуримтлуулах цэгүүдийг нэгтгэх, цөөн байршилд хог хаягдлын түр цэгийн захирамж гаргуулах ажлыг хийж гүйцэтгэнэ. Тэдгээр цэгүүдэд хог хаягдал салхинд хийсэх, хур борооны усанд норхоос сэргийлж хашлага, хамгаалалт хийж тэмдэгжүүлнэ.

11.2.2 Хоол хүнсний хаягдал зайлуулж буй цэгт ариутгал, халдваргүйжилтийг тогтмол хийх.

Кемпийн хог хаягдлын түр цэгт хүнсний хаягдал хуримтлагддаг тул ариутгал халдваргүйжүүлэлтийг тухай бүр хийж хөрсний биологийн бохирдол үүсэхээс сэргийлнэ

11.2.3 Дахивар хаягдлыг ангилан ялгаж, хүлээн авах байгууллагад нийлүүлэх

Дахин ашиглах боломжтой буюу дахивар хаягдалд хаягдал төмөр, дугуй, модон эдлэлийн хаягдал, бүх төрлийн хаягдал цаас, шил, лааз гэх мэт зүйлсийг хамааруулан ойлгоно. Эдгээр хаягдлуудыг ангилал тус бүрээр нь хадгалж дахин ашиглана. Хэрэв төслийн хэмжээнд дахин ашиглах боломжгүй тохиолдолд дараагийн дахин ашиглах байгууллагад шилжүүлнэ.

Эргүүлэн ашиглах боломжтой хаягдлыг хүлээн авагч байгууллагад үнэгүй нийлүүлэх эсвэл тодорхой нөхцөлтэйгөөр тээврийн хөнгөлөлт үзүүлэх замаар нийслэл хот орчмын боловсруулах төвд хүргүүлэхэд нөхцөлийг хангаж ажиллана.

Цаашид хог хаягдлын гарцыг багасгахад зорилгоор нийлүүлэгч буцаан хүлээн авах бололцоог судлах ба эхний ээлжинд үйл ажиллагаанаас гарч буй 1-2 төрлийн хог хаягдлыг нийлүүлэгчид хүлээлгэн өгөх заалтыг гэрээнд тусгаж хэрэгжилтийг хангуулж ажиллан.

11.2.4 Хог хаягдлын урсгалыг хянах, бүртгэлжүүлэх

Хог хаягдлыг ангилал тус бүрээр бүртгэж төрийн захиргааны төв байгууллагад БОХ маягтын дагуу тайлагнаж ажиллана.

11.2.5 Шаардлагатай байршлуудад хог хаягдлын ангилан ялгах савыг шинээр байршуулах

Хог хаягдлын ангилан ялгалтын сайжруулах ажлын хүрээнд оффис, амрах байр, засварын шоп дахь хогийн савыг шинэчилнэ

11.2.6 Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж тухай бүрт нь сумын төвлөрсөн хогийн цэг цэгт буулган төлбөрийг төлж барагдуулна.

“Пи Эй Ар Эй Эн” ХХК ийн төслийн талбайн хэмжээнд үүссэн ахуйн хог хаягдлыг сумын хог хаягдлын төвлөрсөн цэгт хүргэх ба төлбөрийг тухай бүр төлнө.

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, түүнийг бууруулах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах үйл ажиллагааг тусгасан. 2025 онд олборлолтын үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардлагатай бичиг баримт бүрдүүлэлт хийгдэх бөгөөд холбогдох аж ахуй нэгжтэй гэрээ хийхээр төлөвлөж байна.


Төсөл хэрэгжүүлэгч нь үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтийг хянаж, байгаль орчныг хамгаалах ажлын үр дүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөх зорилгоор ОХШХ-т тусгасан арга хэмжээг 2025 оноос хэсэгчлэн хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй. 2025 газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг хийлгэх аж ахуй нэгж сонгон шалгаруулах.

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг /	Нийт зардал /мян.төг/	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Агаарын чанар							
Машин техникийн хөдөлгүүрээс гарах утааны хорт хийн хэмжилт / угаарын хий (CO), азотын дутуу исэл (N ₂ O), хүхэрлэг хий (SO ₂), хүхэрт үстөрөгч (H ₂ S) зэрэг хорт хийг тодорхойлох /	мкг/м ³	Уурхайн машин техникүүдэд	Жилд 1 удаа	Нийт 15 уурхайн тоног төхөөрөмж байна.	30.0	450.0	МУ-ын Засгийн Газрын 213 дугаар тогтоол, Автотээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулах давтамж, оношилгооны төлбөрийн хэмжээ MNS 7.2.1.01-78 Байгаль орчин хамгаалал- Агаар мандал, Дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах агаар мандлыг бохирдуулах хорт бодис
Хөрсний төлөв байдал, чанар							
Хүнд металлууд (ялангуяа Cu, Mo)	мг/кг	4 цэгт	Жилд 1 удаа	0-5, 5-10 см гүнээс 2 ширхэг дээж, нийтдээ 8 ширхэг	110.0	440.0	MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Усны чанар							

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг /	Нийт зардал /мян.төг/	Баримтлах стандарт ба арга, аргачлал
- Хүнд металлын шинжилгээ	мг/л	6 цэгт: Карьер, шүүрлийн ус, худаг	Жилд 6 удаа /гадаргын болон газрын доорх усны чанарыг нэг ижил цаг хугацаанд хийх шаардлагатай/	Мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораторид дээж шинжлүүлэн, дүгнэлт гаргуулна.	55.0	330.0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 6148:2010 Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага
Ургамлан нөмрөг							
Орчны тохижилт ногоон байгууламж байгуулах	Ногоон байгууламжид зориулан тарьсан	Ногоон байгууламж	Жилд нэг удаа	Ногоон байгууламжид зориулан тарих суулгацын	110.0	4,400.0	Тооллого хийх, мэдээлэл цуглуулах

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг /	Нийт зардал /мян.төг/	Баримтлах стандарт ба арга, аргачлал
ажлын хяналт шинжилгээ	мод, сөөгний өвөлжилт, амьдрах чадварыг хянах			хяналт шинжилгээ			
ТӨСЛИЙН 2025 он БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН НИЙТ ЗАРДАЛ /мян.төг/						5,620.0	

Зураг 1 “Баян усны хүрэн нүүрсний ордыг ил аргаар ашиглах” төслийн талбайд санал болгож буй мониторингийн цэгүүдийн байршил



Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж тухай бүрт нь сумын төвлөрсөн хогийн цэг цэгт буулган төлбөрийг төлж барагдуулна.

12.1 Агаарын чанар хяналт шинжилгээ

Уурхайн үйл ажиллагааны үед хөрс чулуулгийн гаралтай тоос тоосонцор ихээр үүсдэг ба уурхайн талбай дахь тээврийн замуудаас үүсэх тоосыг хянах. Төслийн судалгаанаас харахад уурхайгаас үүсэж байгаа тоосонцрын хэмжээ бага байгаа ч замаас тодорхой хэмжээний тоосжилт ажиглагдсан үед бууруулах аргыг сонгон хэрэглэх төлөвлөж байгаа.

12.1.1 Хий төлөвт бохирдуулагчдыг бууруулах арга

Машин механизмын хаягдал утааг бууруулах. Уурхайн бүсэд ашиглагдах байгаа дизель түлшээр ажилладаг хүнд даацын тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, цахилгаан генераторууд нь хий төрлийн бохирдуулагчдын гол эх үүсвэр болно. Дизель хөдөлгүүрийн хаягдал утаанд янз бүрийн агаар

бохирдуулагчид агуулагдах ба ялангуяа азотын ислүүд, хөө тортог(тоосонцор)-н ялгаруулалтын хэмжээ бусад бохирдуулагчидтай харьцуулахад нэлээд их байдаг. Иймд бохирдлын ялгаруулалтыг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх .

- Евро IV- с багагүй зэрэглэлийн түлш ашиглах
- Евро IV- с багагүй зэрэглэлийн хөдөлгүүр бүхий машин тоног төхөөрөмж ашиглах
- Хаягдал утааг цэвэршүүлэх DFU зэрэг фильтр ашиглах

12.1.2 Дуу шуугианы бохирдлыг бууруулах арга

Уурхайн ашиглалтын үед. Ил уурхайн ашиглалтын үед машин, тоног төхөөрөмжийн дуу чимээ, тэсэлгээнээс үүдэлтэй дуу чимээ нь орчны шуугианы түвшнийг нэмэгдүүлнэ. Төслийн ТЭЗҮ-д ил уурхайн ашиглалтын эрчим буюу түүхий эдийн олборлолт, баяжуулах үйл ажиллагаа тасралтгүй явагдах тул шуугианы нөлөөлөл харьцангуй их байна. Уурхайн материал тээвэрлэлтээс үүдэлтэй дуу чимээ нь тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн ажиллагаатай шууд холбоотой тул сул явалтыг багасгах, хөдөлгөөний хурданд хяналт тавьснаар бууруулах боломжтой.

12.2 Төслөөс газрын гадрага, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

- Уурхайн бүсэд ашиглагддаг ердийн шороон замуудыг тэмдэгжүүлж тогтсон нэг маршрутаар зорчих, тухайн замаар зорчих эрхтэй тээврийн хэрэгсэлд замын маршрутыг хэвэлмэл байдлаар өгөх, шаардлаггүй олон салаа зам үүсгэхгүй байх, маршрутаас өөр замаар юмуу эсвэл шинээр зам үүсгэн зорчсон тээврийн хэрэгсэлд хариуцлага тооцох
- Хуулж авсан болон шинээр хуулж хадгалах шимт хөрсийг нөхөн сэргээлтэнд ашиглахаас бусад тохиолдолд олон дахин байршлыг сольж зөөхгүй байхаар тооцож хадгалах талбайг сонгох
- Ил уурхайн бүсэд байгаа ердийн хөрсний өнгөн үе давхаргад (0-5 см) тогтмол мониторинг хийж байх
- Тос, тослох материал асгарсан тохиолдолд шингээж авах, цэвэрлэх элс, хүрз гэх мэт материал багаж хэрэгсэлийг байнга бэлэн байлгах, хэрвээ их хэмжээний (100 л дээш) асгаралт үүсээд цэвэрлэсэний дараа хөрсний органикийн шинжилгээ хийж хянах
- Уурхайн аюулгүй ажиллагаа болон бодисыг хадгалах агуулах савны хяналтыг маш сайн хийх, санамсаргүй тохиолдлоор ямар нэгэн бодис хөрсөнд алдагдаж бохирдолд үүссэн тохиолдолд саармагжуулах болон цэвэрлэх бүх арга хэмжээг авах, цэвэрлээний дараах хяналт мониторингийг хийх

12.3 Төслөөс гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Усны чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах:

- Шүүрлийн усны чанарт байнгын хяналт шинжилгээ хийж байх.
- Овоолгын хүчиллэг урсацыг хянах, урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
- Овоолго болон ил уурхайгаас шүүрэл үүсч байгаа эсэх, үүнтэй холбоотойгоор голын усны чанарт нөлөөлөл үзүүлж байгаа эсэхийг хянах зорилгоор урсгалын чиглэлийн дээд, доод талын хяналтын цооногуудын чанарын мэдээллийг газрын доорх усны чанарын суурь шинжилгээний үр дүнтэй харьцуулан үнэлэлт, дүгнэлт өгч байх;
- Овоолгоос үүсэх шүүрлийн усан сангуудын ус хальж асгарахаас сэргийлж, түвшинд нь байнгын хэмжилт хийж, хянах;

Гадаргын болон газрын доорх усны нөөц, горимд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ:

- Монгол улсын Усны тухай хуулийн 26.1 болон 28.4-р зүйлд заасны дагуу “Пи Эй Ар Эй Эн” ХХК нь ус ашиглуулах дүгнэлтийг төрийн захиргааны төв байгууллагаар гаргуулж, сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авч ус ашиглах гэрээ байгуулах.
- Машин техник угаах зэргийг хориглох
- Хог хаягдал, бохирдуулах бодис хаях, хог хаягдлын цэг байршуулах зэргийг хориглох
- Стандартын шаардлага хангаагүй бохир усны цооног, бие засах газар барьж ашиглах зэргийг хориглох

12.4 Төслөөс ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

- Төслийн талбайд газар зохион байгуулалтыг нарийн төлөвлөх, ажлын зураг төслийг нарийвчлан боловсруулж мөрдөх
- Барилга байгууламжийн ажил дууссаны дараа эвдрэлд орсон талбайг хэлбэршүүлэх, тэгшлэх, үржил шимт хөрсөөр хучих, шаардлагатай тохиолдолд хөрс сайжруулалт хийх зэргээр нөхөн сэргээлт хийх
- Тэгшилж зассан газарт олон наст ургамлын үр цацах, мод, сөөг тарих зэргээр ногоон байгууламж байгуулах
- Ойжуулалт хийх
- Тээврийн хэрэгслийг тогтоосон маршрутаар явуулах, олон салаа зам гаргахгүй байх, замыг тэмдэгжүүлэх
- Автомашины зогсоолын талбайг тэгшлэн шатах, тослох материал хөрсөнд нэвчихээс сэргийлж цардаж өнгөлөх, тэмдэгжүүлэх
- Гал түймрийн болзошгүй аюулаас сэргийлэх
- Төсөл хэрэгжүүлэх орчны ургамлын төрөл зүйл, тархалт, өсөлт хөгжилтөд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх, ургамлан нөмрөгийн байдалд байнгын ажиглалт хяналт тавьж ажиллах.

12.5 Төслөөс амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж

Цагаан зээрийн шилжилт хөдөлгөөн хамгийн идэвхитэй байдаг 9-10 сард тэсэлгээний ажлыг аль болох хийхгүй байхад анхаарч, тэдгээрийн шилжилт хөдөлгөөнд саад учруулахгүй байх. Мөн төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, биологийн олон янз байдлыг хамгаалах, амьдрах орчныг сайжруулах зорилгоор “Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө”-г боловсруулах нь тохиромжтой гэж үзэн дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг боловсруулан тайлангийн 7 хэсэгт дэлгэрэнгүй тусгав.

12.6.Төслөөс иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ

Ил уурхайн өрөмдлөг, тэсэлгээний үйл ажиллагаанд ашиглах явцад ажиллагсдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах:

- Ил уурхайн технологийн онцлогтой холбоотой ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, цаашлаад гарз хохирол их хэмжээгээр учруулж болзошгүй осол аюул тохиолдохоос сэргийлэх зорилгоор хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцлийг бүрэн хангах, ажилчдыг хувийн хамгаалах хэрэгслээр иж бүрэн хангах тал дээр тавьдаг хяналтыг байнга хийх;
- Химийн бодис, гал унтраах төхөөрөмж зэрэгтэй ажиллах аюулгүй ажиллагааны журамтай бүх ажилтнууд сайтар танилцсан байх;
- Химийн бодис бүтээгдэхүүн алдагдах аюул осол гарсан тохиолдолд анхан шатны тусламж үзүүлэх хэрэгслээр бүрэн хангаж, чанар, ажиллагааг нь байнга шалгаж байх;
- Химийн хорт нэгдэл, тоос тоосонцороор дамжин хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад тустай арга хэмжээг тусгасан компанийн зүгээс гаргасан тоосжилтыг бууруулах арга хэмжээний заавар зөвлөгөөнд тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх;
- Химийн бодис болон бусад хортой нэгдлийн нөлөөнд хүн амаар буюу унд, хоол хүнсээр, амьсгалаар болон арьсаар хүрэлцэх замаар өртдөг тул ажиллагсдын эрүүл ахуйн горим, хувийн ариун цэврийг сахих тал дээр онцгой анхаарал тавьж ажиллан гар, арьс, үс зэргийг бохирдохоос сэргийлэх, гараа зөв бүрэн угааж, усанд тогтмол орж занших ажлыг ажилтнуудад хэвшүүлэх;
- Бүх галын эх үүсвэрийг холдуулж, гал унтраах тоног төхөөрөмж хэрэглэх боломжийг байнга бүрдүүлж ажиллах
- Химийн бодис ачиж буулгах, тээвэрлэх үеийн аюулгүй ажиллагаа, химийн бодис асгарч алдагдсан үед авах арга хэмжээний талаар ажиллагсдыг тогтмол сургалтанд хамруулж, мэдлэгийг шалгаж байх
- Химийн бодистой шууд харьцаж ажилладаг ажиллагсдыг үйлдвэрлэлийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй ажиллах, тэдгээрийг ашиглах дадал эзэмшүүлэх болон аюулгүй ажиллагааны сургалтанд тогтмол хамруулж, мэдлэгийг шалгаж байх
- Технологийн уусмал бэлтгэх үед технологийн болон аюулгүй ажиллагааны шаардлагыг нарийн баримталж ажиллах

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар авах арга хэмжээ:

Тусгай зөвшөөрөл эзэмшигч:

“Пу Эй Ар Эй Эн” ХХК

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-015616

- Уурхайд ажиллагсад нь нүүрс олборлох, зөөх, тээвэрлэх үйл ажиллагааны үед осол гэмтэл гарах тохиолдол байдаг бөгөөд эдгээр осол, гэмтэл нь бартаатай замын улмаас гулсах, унах, ажлын талбар нь халтиргаатай байх, ажлын зам нь өндөр гадаргуутай буюу тодорхой бус байх болон ажлын байрны дүрмийн бус үйл ажиллагааны уршгаар гардаг. Осол гэмтэл гаргахгүй байх арга хэмжээ нь зам талбайг сайжруулах, техник, тоног төхөөрөмжийн тохируулга үзлэгийг тогтмолжуулах, техникийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих, ажилчдыг ажил мэргэжилд нь сайтар мэргэшүүлэх, хөдөлмөр хамгаалалд сайн сургах, мэдлэг чадварыг дээшлүүлэх явдал юм.
- Тэсрэх, дэлбэрэх бодистой харьцах нь аюултай тул зөвхөн мэргэжиж дадлагажсан ажилчдыг ажиллуулах ба аюулгүй ажиллагааны заавар, дүрмийг заавал мөрдөж хэвшүүлэх хэрэгтэй.
- Экскаваторуудын ажлын байрны хөргөлт, дулаалгын асуудлыг улирлын онцлогт тохируулан техникийн арга хэмжээ авах хэрэгтэй.
- Нүүрсхүчлийн хийн хэмжээ хэтэрсэн ажлын байруудад төлөвлөгөөний дагуу агааржуулалтын системийг ажиллуулах, шаардагдах зардал мөнгийг төсөвт тусгах нь зүйтэй.


Ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ:

- Хүйтний улиралд ажилчдад норм ын дулаан хувцас, хамгаалах хэрэгслийг олгож байх хэрэгтэй.
- Доргио чичиргээний норм хэтэрсэн ажлын байранд ажиллагсдыг хамгаалах хэрэгслээр төлөвлөгөөний дагуу бүрэн хангах хэрэгтэй.
- Жил бүрийн уурхайн нэгдсэн төлөвлөгөөнд эрүүл ахуй, ажлын байрны нөхцөлийг сайжруулах талаар бүрэн тусгаж, стандарт хэмжээнд барьж ажиллах нормыг тогтоож ажиллах нь зүйтэй.
- Химийн хортой болон аюултай бодистой харьцаж ажиллагсдад батлагдсан нормоор сүү олгож байх зэрэг болно.

13. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

13.1 Удирдлагын бүтэц, хүний нөөц

Ажилчдын орон тоог төслийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай техник технологи, төслийн хүчин чадал, тоног төхөөрөмжийн тоо нэг бүрээс хамааруулан гаргасан.



Тусгай зөвшөөрөл эзэмшигч:

“Пу Эй Ар Эй Эн” ХХК

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-015616

Удирдлага зохион байгуулалт

Нийт ажилчдаас уурхайн захиргаа, удирдлагын хэсэгт 16 хүн, уулын хэсэгт 176-287 хүн, засвар механикийн хэсэгт 44 хүн, аж ахуй үйлчилгээний хэсэгт 76 хүн, нийт 327 хүний ажлын байр бий болохоор байна. Уурхайн орон тооны бүтэц, ажлын байрны төрөл, ажлын байрны бүтцийг доорх хүснэгтэд тус тус ялган харууллаа.

Хүснэгт 2.1 Орон тооны бүтэц

№	Орон тооны төрөл	1 дэхь жил	2дах жил	3-9 дэхь жил	10 дах жил
1	ИТА	48	48	48	48
2	Оператор	84	144	204	116
3	Ажилчин	72	72	72	72
4	БТА	123	123	123	123
	Нийт ажилчид	327	327	447	359

Уурхай нь уртасгасан ээлжээр ажиллах бөгөөд 14 хоног ажиллаад 14 хоног амрах хувиартай байна.

13.2 Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээний талаар төлөвлөгөө

Байгаль хамгаалах чиглэлээр:

- Жил бүр Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан, биелэлтийн талаар олон нийтэд тайлагнах ажлыг зохион байгуулах
- Үйлдвэрийн ойр орчимд ногоон ургамал тарих, мод суулгаж, суулгасан модны ургалтын байдлыг тогтмол хянаж, ургахгүй байвал нөхөн суулгах ажлыг зохион байгуулах хэрэгтэй.
- Байгаль орчны аудит хийх эрх бүхий мэргэжлийн байгууллагаар 2 жил тутам Байгаль орчны аудит хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх бөгөөд зөвлөмжид заасан хугацаанд тайлангаа Дорнод аймгийн БОАЖГ-т хүргүүлнэ /Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10¹-р зүйл/
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн “Нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх тухай” 01/190 албан тоотод заасны дагуу Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайд уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон талбайн техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэн, нөхөн сэргээсэн талбайн эзлэх хувийг нэмэгдүүлэх, жил бүрийн БОМТ-ний биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах болон нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд аймгийн БОАЖГ-аас тогтоосон орон нутаг дахь эвдрэлд орж, олон жил нөхөн сэргээлт хийгдээгүй талбайн нөхөн сэргээлтийг хийж, орон нутагт актаар хүлээлгэн өгөх, БОАЖЯ-ны Төрийн сангийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд тухайн жил бүрийн БОМТ-г хэрэгжүүлэх арга

Тусгай зөвшөөрөл эзэмшигч:

“Пу Эй Ар Эй Эн” ХХК

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-015616

хэмжээнд шаардагдах зардлыг холбогдох хуульд заасан хувь хэмжээг төвлөрүүлсэн баримтын тооцоо нийлэх,

- Нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах чиглэлээр зохион байгуулж буй арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, үр дүнг хянах

Төслөөс нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах:

- Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах
- Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийг баримталж ажиллах /Засгийн Газрын 2019 оны 313 дугаар тогтоолын хавсралт/
- Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр хамруулах
- Техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд байнгын хяналт тавих
- Ажилчдын ажлын байрны аюулгүй Уурхайн үйл ажиллагаагаар үүссэн нарийн ширхэглэгт тоосонцор нь салхиар зөөгдөн оршин суугчид, ажиллагсдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлж, ажиллагсдад тусгай зориулалтын амны хаалт, хэрэгсэл олгох
- Ажиллагсдыг жил бүр эрүүл мэндийн үзлэгт оруулж, уурхайн ажилчдын өвчлөлтийн талаар судалгаа дүгнэлт гаргуулах
- Хоолны газар, ажлын байрны эрүүл ахуйд хяналт тавьж ажиллах
- Дуу чимээ ихтэй нөхцөлд ажиллах ажиллагсдад зориулалтын чихний бөглөө олгох
- Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх багаж хэрэгслийг ажлын байруудад зохих шаардлагын дагуу бэлтгэн байрлуулах
- Уурхайн ажилчдад хөдөлмөрийн аюулгүй байдал, аврах багийн хүрээнд тогтмол сургалтанд хамруулах
- Уурхайн тоног төхөөрөмж, ахуйн хаягдал цэг, сав агуулахуудын байрлах газрыг байгаль орчинд халгүй, хүмүүсийн аюулгүй ажиллах, амрах бүх нөхцөлийг хангах зорилгоор зөв байрлуулах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

14. НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Матад сумын Буян өндөр багийн иргэд малчидад Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан, биелэлтийн талаар олон нийтэд тайлагнах ажлыг зохион байгуулах.

Олон нийтийн уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах жилд 1-2 удаа үйл ажиллагааны зардалд тусгах бөгөөд төслийн талбайд явагдан.

15. БАЙГАЛТ ОРЧНЫ МЕНЕЖЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨВ

№	Зардлын төрөл	2025 он /мян.төг/
---	---------------	----------------------

1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	4,130.00
1.1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	880.00
1.2.	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	1,500.00
1.3.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,100.00
1.4.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	650.00
2	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	5,620.00
2.1.	Агаарын чанар	450.00
2.2.	Хөрсний төлөв байдал, чанар	440
2.3.	Усны чанар	330.00
2.4.	Ургамлан нөмрөг	4,400.00
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ /мян.төг/		9,750.00

16. ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР

Бүлэг	Арга хэмжээ	Хамрах хүрээ, давамж	Биелэлийн шалгуур	Эзлэх жин
5	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө			20
5.1	Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах төлөвлөгөө			4
5.1.1	Уурхайн дотоод тээврийн зам дээрх тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нь тоосжилтын хамгийн гол эх үүсвэр бөгөөд хаягдал чулуулаг тээвэрлэлтэд 90 тн даацтай автосамосвал, нүүрс тээвэрлэлтэд 55 тн даацтай автосамосвал ашиглаглах	Ил уурхай	ТЭЗҮ заасан тоног төхөөрөмж ашиглалт	0.5
5.1.2	Кемп хоорондын зам болон ачаа тээврийн сайжруулсан шороон замын засвар үйлчилгээ, арчилгааны хуваарь гарган батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах	Төслийн талбай	Сайжруулсан шороон замын засвар үйлчилгээний хуваарийг бүх гэрээт компаниудыг оролцуулан боловсруулж батлуулан хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан байна.	1
5.1.3	Замуудаас үүсэх тоосжилтын хэмжээг тооцохдоо ашиглалтын хугацаанд замаас үүсэх нийт тоосыг байгалийн хур тунадас болон усалгаагаар бууруулах.	Ил уурхай	Уурхайн хэмжээнд усалгааны машиныг тогтмол байлгана.	0.5
5.1.4	Уурхайн дотоод зам талбайд зорчиж буй хөнгөн тэрэг болон уулын машин механизмуудад хурдны хязгаар тогтоож, гэнэтийн хэмжилт шалгалт хийх	Ил уурхай / сар бүр	Сар бүр уурхайн хөдөлгөөнт техникүүдэд хяналт шалгалтыг тогтмол хийсэн байна.	0.5

5.1.5	Нүүрс тээвэрлэлтийн машинуудын хяналт	Нүүрс тээврийн маршрут	Нүүрс тээвэр, ложистикийн хэлтэстэй хамтран нүүрс тээвэрлэлт хийж буй машинуудыг бүтээлэгтэй байлгаж, зөвшөөрөгдсөн замын маршрутын дагуу тээвэрлэлт хийж байгаа эсэхэд тогтмол хяналт хийж ажиллана	0.5
5.1.6	Ашиглаж буй техник хэрэгслүүдийг автотээврийн хяналтын үзлэгт оруулах	Жил бүр улсын үзлэгт/дотоодод улиралд нэг	Үйлдвэрлэл техникийн газрын Засвар механикийн хэлтэстэй хамтран уурхайн ажилд ашиглагдаж буй автомашинуудыг тээврийн хэрэгслийг жилд нэг удаа огтсон хугацаанд үзлэгт хамруулах ажиллана. Мөн дотооддоо техникийн үзэг алгалтыг хуваарь гаргаж долоо хоног бүр хамруулж, таа их хаядаг, стандартад нийцэхгүй тээврийн эрэгслийг ажлын талбайд гаргахгүй байх дээр хяналт тавьх	0.5
5.1.7	Агаарын чанарын хяналт	Сар бүр	Агаарын чанарын суурин 1 ширхэг станцны худалдан авалтыг хийж, Дорнодаймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт дүн мэдээг онлайнаар өгч ажиллана	0.5
5.2	Гадаргын болон газрын доорхи усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ			4
5.2.1	Худагт бохирдол алдагдахаас сэргийлэх, холбогдох шаардлага, стандартын дагуу худгийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байгаа эсэхэд тогтмол хяналт тавина.	Эзэмшлийн худгууд	Сар бүр тогтмол үзлэг шалгалтыг хийнэ.	1
5.2.2	Ус ашиглуулах дүгнэлт гаргуулж, ус ашиглах гэрээ байгуулах, төлбөрийг тогтмол хугацаанд төлөх	Сар бүр	Ус ашиглах дүгнэлтийг гаргуулж дүгнэлтэнд заагдсаны дагуу холбогдох гэрээг байгуулж төлбөрийг сар бүрийн тоолуурын заалтыг сумын байгаль хамгаалагчаар баталгаажуулж төлбөрийг тогтмол хугацаанд нь төлсөн байна	1

5.2.3	Хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ байгуулан төлбөр төлөх	Жил бүр	Цэвэрлэх байгууламжаас гарч буй цэвэршүүлсэн бохир ус нь стандартад нийцэж байгаа эсэхийг улирал тутамд хянаж, итгэмжлэгдсэн лабораторид усны дээжийг шинжлүүлэх ба шинжилгээний дүнд үндэслэн уурхайн зам талбайн тоосжилт дарах, мод услахад ашиглана	1
5.2.4	Бохир ус зөвшөөрөлтэй газар нийлүүлэх, саарал усыг дахин ашиглах зөвшөөрөл	Жил бүр	Хаягдал усыг зориулалтын зөвшөөрөлтэй газарт нийлүүлэх түүнд хяналт тавих, стандарт шаардлагад шаардлагад нийцсэн цэвэршүүлсэн бохир усаар зам талбайн тоосжилт дарах, мод услахад ашиглана	1
5.3	Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөө			4
5.3.1	Нүүрс ус төрөгчийн хяналтгүйгээс хөрс бохирдох	Тухай бүр	Ажлын байрны үзлэг болон техникийн тойрох үзлэг шалгалтаар асгаралт үүсэх өндөр магадлалтай техник төхөөрөмж, объектуудад урьдчилсан үзлэг хийж хариу арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлнэ.	1
			Асгаралт гарсан тохиолдолд нөлөөллийг хязгаарлах, орчин тойрныг бохирдуулахгүй байхад бэлэн байх нөхцөлийг хангаж асгаралтын иж бүрдлийг бэлэн байлгана	1
			Саармагжуулах бодисын бэлэн байдлыг бэлэн байлгах, асгаралт үүсч болзошгүй засварын төв зэрэг барилгуудад асгаралтын иж бүрдлийн бэлэн байдлыг нөөцлөх шаардлагыг чандлан мөрдөнө.	1
5.3.2	Технологийн горимын мөрдөлтийг хангуулах ажиллагаа		Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгын технологийн горимыг хангуулж байгаль орчны чиглэлийн дотоодын журам, горимуудыг мөрдөнө.	1

5.4	Газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ			2
5.4.1	Зөвшөөрөлгүй газар хөндөхөөс сэргийлж, аливаа газар хөндөх ажлыг эхлүүлэхээс өмнө газар хөндөх зөвшөөрөл олгох, хөндөгдсөн газрын бүртгэлийг мэдээллийн санд оруулах	Тусгай зөвшөөрөлтэй талбайн хэмжээнд жилийн турш	Газар хөндөх зөвшөөрлийг баталсан журам, зохион байгуулалтын дагуу хэрэгжүүлэн, газар хөндөх зөвшөөрлийн үйл явцад сайжруулалт хийж газрын хэмжээг GIS систем болон нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.	1
5.4.2	Тусгай зөвшөөрөлгүйгээр түгээмэл тархацтай ашигт малтмал, ус, ургамал ашиглахгүй байх, хяналт хийх	Тусгай зөвшөөрөлтэй талбайд сар бүр тогтмол	Холбогдох зөвшөөрөлгүйгээр түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахгүй байлгах үүднээс Уурхайн гадаад бүсэд байгаль орчны нийцлийн хяналт хийх журам /ЭТТ-СА-Ж05-БО-Ж01-Х01/-ын дагуу тогтмол хяналт хийнэ.	1
5.5	Ургамлан нөмрөгт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах			2
5.5.1	Нэн ховор, ховор ургамлыг шилжүүлэн суулгах	Тухайн жилийн ахилтын хүрээ	Тусгай зөвшөөрлийн талбайд олборлолтонд өртөх талбайн нэн ховор, ховор ургамлын тархацын судалгааг хийж координат цэгийг тэмдэглэх. Фото зургаар баталгаажуулан, ургамлын хамтаамал бэлтгэх	1
5.5.2	Уурхайн ахилтанд өртөж болзошгүй ховор болон, нэн ховор ургамлын байршлыг тогтоож, мэдээллийн санд оруулах, өртөх тохиолдолд шилжүүлэн суулгах	Тухайн жилийн ахилтын хүрээ	Уурхайн ахилтад өртөх талбайд ховор, нэн ховор ургамлын тархалтын судалгааг хийж тухайн талбайд бүртгэгдсэн ургамлыг Байгалийн ургамлыг хамгаалах, удмын санг нэмэгдүүлэх зорилгоор мод үржүүлгийн талбайд шилжүүлэн суулгана	1
5.6	Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө			4

5.6.1	Уурхайн үйл ажиллагааны шууд болон дам нөлөөллөөр биологийн олон янз байдалд өртөх эрсдэлээс хамгаалах аргыг тодорхойлохын тулд өртөлтийн судалгаа хийх	Төслийн хэмжээнд	Дотоод бололцооны дагуу хийж Гүйцэтгэхээр төлөвлөж байна.	2
5.6.2	Хулгайн ангаас сэргийлэх хууль эрхзүйн сургалтыг орон нутгийн цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулах	Төслийн хэмжээнд	Төслийн хэмжээнд гэрээт болон туслан гүйцэтгэгч компаниудын байгаль орчны мэргэжилтнүүдтэй хамтран хууль бус хулгайн антай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах олон хориотой ан амьтны талаарх сургалтыг зохион байгуулна.	2
6	НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨН			25
6.1	Техникийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө		2025-2028 онд биологийн нөхөн сэргээлт хийх төлөвлөгөө байхгүй	0
6.2	Биологийн нөхөн сэргээлтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө			0
6.2.1	Шимт хөрс овоолго хэлбэржүүлэх		Стандартын дагуу овоолго хэлбэржүүлэх, Ургамал тарих	10
6.3	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн			15
6.3.1	Дорнод аймгаас хуваарилсан 350 модны төлөвлөгөө боловсруулж, батлуулах.	Дорнод аймгийн хэмжээнд	Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Дорнод аймаас хуваарилсан 350 модны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, хэрэгжүүлж эхлүүлнэ.	7.5
				7.5
7	БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА			15

7.1	Жаран тогооны тал хэмээх аймгийн ТХГН дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд зэрлэг амьтдыг хамгаалах биотехникийн арга хэмжээ төлөвлөж, хэрэгжүүлэх /өвлийн цас ихтэй үед зэрлэг амьтанд өвс тэжээл, хужир шүү тавих/, дүйцүүлэн хамгаалал хийгдэх газрын биологийн олон янз байдлын суурь судалгаа хийлгэх зэрэг ажлууд	Гэрээт	Орон нутгийн иргэд болон аж ахуй нэгжтэй гэрээлэх тайлан мэдээллийг аван хяналт тавих.	15
8	НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ			5
8.1	НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ	Тухай бүрт	Тус төслөөс орон нутгийн иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллагыг нүүлгэн шилжүүлэх шаардлагагүй.	5
9	ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ			5
9.1	ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭЙ	Тухай бүрт	Төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих орчны түүх, соёлын өв дурсгалд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй. Олдсон тохиолдолд олборлолт зогсоож холбогдох байгуулгад мэдэгдэнэ.	5
10	ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ			12
10.1	Нүүрс устөрөгч, Химийн бодис хяналтгүйгээгээр асгарах			4
10.1.1	Ажилтнуудыг химийн бодисын хор аюул, түүнтэй хэрхэн харьцах, асгарч, алдагдсан үед авах арга хэмжээ, хувийн хамгаалах хэрэгсэл, анхны тусламж, галын аюулын үед авах арга хэмжээний талаар сургалтанд хамруулах	Ил уурхай	Химийн бодистой харьцаж ажилладаг бүх ажилчид	2
10.1.2	Шингэн хаягдлын сав баглаа боодол задарч, асгарах	Ил уурхай	Асгаралт гарсан тохиолдолд бүрийг бүртгэлжүүлж, хариу арга хэмжээг байнга авч, бохирдсон хөрс тусгай	2

			талбайд байршуулна.	
10.2	Гал түймэр			4
10.2.1	Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм журам боловсруулж түүнийг дагаж мөрдөх.	Ил уурхай	“Галын аюулгүй байдлын журам”-ыг мөрдөж ажиллана.	1
10.2.2	Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалын заасан самбар галын аюул болж болзошгүй газруудад анхааруулах зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байрлуулах, хяналт тавих	Ил уурхай	Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалын заасан самбар галын аюул болж болзошгүй газруудад анхааруулах зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан эсэхэд хяналт тавина.	1.5
10.2.3	Шатахуун түгээх станцын талбайд ил гал гаргахыг хориглосон, анхааруулсан тэмдэг, санамж байрлуулах, үерээс хамгаалсан суваг, шуудууг татах, сэргээх	Ил уурхай	Уурхайд байрлах зөөврийн ШТС-ыг хамгаалсан үерийн суваг шуудууг сэргээн засварлах, ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэх, ажлын байрны үзлэг хийж зөрчил дутагдлыг арилгах, тэмдэг тэмдэглэгээг сэргээх ажлуудыг тогтмол хийнэ.	1.5
10.3	Байгалийн аюул, гамшигт нөхцөл байдал			4
10.3.1	Уурхайн Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулах	Уурхайн хэмжээнд	Төлөвлөгөөг холбогдох байгууллагуудын удирдлагаар батлуулна.	1
10.3.2	Уурхайн Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг нийт ажилтнуудад танилцуулах	Уурхайн хэмжээнд	Төслийн хэмжээнд гэрээт болон туслан гүйцэтгэгч компаниудын ажилтнууд />100/-д танилцуулна.	2

10.3.3	Үерийн эрсдэл бүхий цэгүүдэд байгуулсан ус зайлуулах суваг шуудууг сэргээх	Уурхай, хотхоны хэмжээнд	Уурхай болон жилтнуудын хотхоныг үерийн уснаас хамгаалах ус зайлуулах шугам, хамгаалах даланг шаардлагатай газруудад хийнэ.	1
11	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө			5
11.1	Аюултай хог хаягдал			2
11.1.1	Хаягдал тосны байгууламжийг стандартын дагуу байгуулах	Уурхай, хотхоны хэмжээнд	Хаягдал тос цуглуулах талбайг нэвчилтээс сэргийлж, бетон суурьтай болгоно.	1
11.1.2	Аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй ААН-д шилжүүлэх	Уурхайн хэмжээнд	Тусгай зөвшөөрөлтэй компанитай гэрээ байгуулан, нийлүүлнэ.	1
11.2	Ахуйн хог хаягдал			3
11.2.1	Уурхайн хог хаягдлын түр цэг тогтоолгож, хашлага хамгаалалт хийж тэмдэгжүүлэх	Уурхай, хотхоны хэмжээнд	Хог хаягдлын түр цэгийн байршлыг тогтоож, захирамж гаргуулна.	1
11.2.2	Хоол хүнсний хаягдал зайлуулж буй цэгт ариутгал, халдваргүйтгэлийг тогтмол хийх	Уурхай, хотхоны хэмжээнд	Ариутгал халдваргүйтгэлийг тогтмол хийнэ	1
11.2.3	Дахивар хаягдлыг ангилан ялгаж, хүлээн авах байгууллагад нийлүүлэх	Уурхай, хотхоны хэмжээнд	Дахивар хог хаягдал ялган ачиж явуулах	0.5
11.2.4	Шаардлагатай байршлуудад хог хаягдлын ангилан ялгах савыг шинээр байршуулах, шинэчлэх	Уурхай, хотхоны	Хогийн сав нэмж байршуулна.	0.5

		ХЭМЖЭЭНД		
12	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр			5
12.1	Агаарын чанарын хяналт шинжилгээ			2
12.1.1	Агаар дахь тоосонцорын хэмжилт	Нийт 4 цэгт: 1.Уурхайн ухаш орчим 2.Тэсэлгээний өмнө /салхины чиг, бусад хүчин зүйлийг харгалзан цэгээ сонгоно/ 3.Тэсэлгээний дараа /салхины чиг, бусад хүчин зүйлийг харгалзан цэгээ сонгоно/ 4.Уурхайн нүүрс тээврийн зам орчим	Уурхайн мониторингийн цэгүүд дээр TSP, PM10, PM2.5 хэмжилтийг сард нэг удаа хэмжилт хийх)	0.2
12.1.2	Орчны агаарт агуулагдах тоосонцрын агууламж, хүхэрлэг хийн хэмжээ, азотын давхар ислийн хэмжээг тодорхойлно		Жилд 1 удаа Мэргэжлийн байгуулагаар	0.4
12.1.3	Уурхайн орчмын дуу чимээний төвшинг тодорхойлно		Дуу чимээний хэмжилт Жилд 2 удаа	0.2
12.1.4	Агаарт агуулагдах тоосонцорт Co, Cu, Fe, Pb, Ag гэх мэт хүнд металлын агууламжийг тодорхойлно		Жилд 1 удаа	0.4
12.1.5	Агаарт агуулагдах тоосонцорт Co, Cu, Fe, Pb, Ag гэх мэт хүнд металлын агууламжийг тодорхойлно		Агаар дахь хүнд металлуудын агууламжийг тодорхойлох Жилд 1 удаа	0.4
12.1.6	Машин техникийн хөдөлгүүрээс гарах утааны хорт хийн хэмжилт. Уурхайн тоног төхөөрөмж	Уурхайн машин техникүүдэд	Машин техникийн хөдөлгүүрээс гарах утааны хорт хийн хэмжилт / угаарын хий (CO), азотын дутуу исэл (N2O), хүхэрлэг хий (SO2), хүхэрт устөрөгч (H2S) зэрэг хорт хийг тодорхойлох	0.4
12.2	Хөрсний төлөв байдал, чанар			1
12.2.1	Хүнд металлууд (ялангуяа Cu, Mo)	4 цэгт	0-5, 5-10 см гүнээс 2 ширхэг дээж, нийтдээ 8 ширхэг Жилд 1 удаа	1

12.3	Усны чанар			1
12.3.1	Хүнд металлын шинжилгээ	6 цэгт: Карьер, шүүрлийн ус, худаг	Жилд 2 удаа /гадаргын болон газрын доорх усны чанарыг нэг ижил цаг хугацаанд хийх шаардлагатай	1
12.4	Ургамлан нөмрөг			1
12.4.1	Орчны тохижилт ногоон байгууламж байгуулах ажлын хяналт шинжилгээ	Ногоон байгууламж /Жилд нэг удаа	Ногоон байгууламжид зориулан тарьсан тарьц суулгацын хяналт шинжилгээ	1
13	Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө			3
13.1	Үйлдвэрийн ойр орчимд ногоон ургамал тарих, мод суулгаж, суулгасан модны ургалтын байдлыг тогтмол хянаж, ургахгүй байвал нөхөн суулгах ажлыг зохион байгуулах.	Төслийн талбай	Засвар үйлчилгээний талбай болон уурхайн хотхонд мод тарих	1.5
13.2	Нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах чиглэлээр зохион байгуулж буй арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, үр дүнг хянах	Орон нутаг	Орон нутгийн гэрээт аж ахуй нэгжээр гүйцэтгүүлэх. Гүйцэтгэлт тогтмол хяналт тавих	1.5
14	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө			5
14.1	Жил бүр Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах.	Орон нутаг	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан, биелэлтийн талаар олон нийтэд тайлагнах ажлыг зохион байгуулах	2.5
14.2	Матад сумын Буян-Өндөр багийн иргэд	Жилд 1 удаа	БОМТ-ний биелэлтийг танилцуулсан байна.	2.5

Нийт	100
------	-----